CAMPUS CONNECTIONS

ОЮУТНЫ ХОТХОН ДАХЬ ХОЛБООСУУД

U.S. DEPARTMENT OF STATE / BUREAU OF INTERNATIONAL INFORMATION PROGRAMS
АНУ-ЫН ТӨРИЙН ДЕПАРТАМЕНТ / ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧОО

All copyrights obtained through the Bureau of International Information Programs (IIP), U.S. Department of State.

Өгүүлэгүүдийн зохиогчийн эрхийг АНУ-ын Төрийн Департментийн Олон Улсын Мэдээллийн Хөтөлбөрийн Товчоогоор (ОУМТ) дамжуулан авсан болно.

U.S. DEPARTMENT OF STATE / AUGUST 2009
VOLUME 14 / NUMBER 8
http://www.america.gov/publications/ejournalusa.html

International Information Programs:

Coordinator	Jeremy F. Curtin
Executive Editor	Jonathan Margolis
Creative Director	George Clack
Editor-in-Chief	Richard W. Huckaby
Managing Editor	Charlene Porter
Associate Editor	Joshua K. Handell
Production Manager	Janine Perry
Graphic Designer	Sylvia Scott
Copy Editor	Kathleen Hug
Photo Editor	Ann Monroe Jacobs
Cover Designer	David Hamill
Reference Specialist	Martin Manning

Cover: Specially designed by Teshkeel Media for eJournalUSA, our cover features three characters from the comic book series THE 99. Bari the Healer (center left) channels energy to heal wounds and mend broken bones. Jabbar the Powerful (center) has muscles that swell to make him supernaturally strong. Noora the Light (standing center) has the ability to perceive and confront others with the truth within themselves. The creator of THE 99, Naif Al-Mutawa, is interviewed in the article "Superheroes Arise From a Life in Two Nations."

Cover Art: Ron Wagner
Color: Steve Buccellato
Lettering: Comicraft's Albert Deschesne
THE 99 are copyright © 2009 Teshkeel Media Group

Opposite: Another hero of Al-Mutawa's THE 99, Jami the Assembler is an engineering and electronics genius whose superpowers seem as suited to the classroom as they are in the fight for justice.

Art: June Brigman and Roy Richardson
Color: Steve Buccellato

АНУ-ЫН ТӨРИЙН ДЕПАРТАМЕНТ / 2009 ОНЫ
8 ДУГААР САР / 14 ДЭХ ДЭВТЭР / ДУГААР 8
http://www.america.gov/publications/ejournalusa.html

Олон улсын мэдээллийн хөтөлбөр:

Зохицуулагч	Жереми Ф. Кэртин
Гүйцэтгэх эрхлэгч	Жонатан Марголис
Уран сайхны захирал	Жорж Клак
Ерөнхий эрхлэгч	Ричард В. Хакаби
Эрхлэгч	Чарлен Портер
Орлогч эрхлэгч	Жошуа К.Ханделл
Хэвлэлийн менежер	Жанин Перри
Зураг дизайнч	Силвиа Скотт
Дугаарыг эрхлэгч	Катлийн Хаг
Зургийн эрхлэгч	Анн Монро Жакобс
Хавтасны загварыг	Дэвид Хамилл
Лавлагааны мэргэжилтэн	Мартин Маннин

Хавтас: Хавтасны зургийг Teshkeel Media-гаас eJournal USA-д зориулан тусгайлан хийхдээ THE 99 хошин зургийн цувралын гурван дүрийг оруулсан. Анагаагч Бари (голын эгнээний зүүн талд) энергийг ашиглан шархыг эдгээж, хугарсан ясыг буцаан нийлүүлдэг. Хүчит Жаббар (төвд) нь түүнд ер бусын хүчийг авчирдаг хийлсэн мэт томрогч булчинтай. Гэрэл цацруулагч Ноора (төвд нь зогсож байгаа) бусдыг ойлгож, тэдэнд дотоод үнэнийг нь мэдрүүлдэг. THE 99 –ийг зохиогч Найф Ал-Мутава-тай "Хоёр улсын амьдралаас шилдэг баатрууд төрдөг" нийтлэлд ярилцсан байгаа.

Хавтасны загвар: Рон Вагнер
Өнгө: Стив Букеллато
Бичиглэл: Comicraft-ын Алберт Десчесн
THE 99 нь 2009 оны Teshkeel Media-гийн зохиогчийн эрхтэй.

Эсрэг тал: THE 99-ийн бас нэгэн баатар болох угсрагч Жами бол инженер, электроникийн суут ухаантан. Түүний хүч чадал нь шударга ёсны төлөө тэмцэх хүч чадлын нэгэн адил сургуулийн танхимд маш тохирсон хүч чадал юм.

Загвар: Жюнь Брайман болон Рой Ричардсон
Өнгө: Стив Букеллато

The Bureau of International Information Programs of the U.S. Department of State publishes a monthly electronic journal under the eJournal USA logo. These journals examine major issues facing the United States and the international community, as well as U.S. society, values, thought, and institutions.

One new journal is published monthly in English and is followed by versions in French, Portuguese, Russian, and Spanish. Selected editions also appear in Arabic, Chinese, and Persian. Each journal is catalogued by volume and number.

The opinions expressed in the journals do not necessarily reflect the views or policies of the U.S. government. The U.S. Department of State assumes no responsibility for the content and continued accessibility of Internet sites to which the journals link; such responsibility resides solely with the publishers of those sites. Journal articles, photographs, and illustrations may be reproduced and translated outside the United States unless they carry explicit copyright restrictions, in which case permission must be sought from the copyright holders noted in the journal.

The Bureau of International Information Programs maintains current and back issues in several electronic formats at *http://www.america.gov/publications/ejournalusa.html.* Comments are welcome at your local U.S. Embassy or at the editorial offices:

Editor, eJournal USA
IIP/PUBJ
SA-5, 1st Floor
U.S. Department of State
2200 C Street, NW
Washington, DC 20522-0501
United States of America
E-mail: eJournalUSA@state.gov

АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын Мэдээллийн Хөтөлбөрийн товчооноос eJournal USA логотойгоор сар тутмын цахим сэтгүүлийг хэвлэн гаргадаг. Энэ сэтгүүл нь АНУ-д болон олон улсын хамтын нийгэмлэгт тулгарч буй тулгамдсан асуудлууд, түүнчлэн АНУ-ын нийгэм, үнэт зүйлс, сэтгэлгээ, институцуудыг тусгадаг. Сар тутам Англи хэл дээр нэг шинэ дугаар хэвлэгддэг бөгөөд хувийг нь Франц, Португал, Орос, Испани хэл дээр орчуулан гаргадаг. Зарим сонгосон дугааруудыг Араб, Хятад, Перс хэл дээр гаргана. Сэтгүүл бүр нь дэвтэр, дугаараараа каталогид ордог.

Сэтгүүлд гарсан үзэл бодол нь АНУ-ын Засгийн газрын байр суурь, бодлогыг заавал илэрхийлэх албагүй. АНУ-ын Төрийн Департамент нь сэтгүүл дэх холбоос бүхий интернэт сайтуудын агуулга, тэдгээрт байнга нэвтрэх боломжтой байх асуудлаар хариуцлага хүлээхгүй бөгөөд энэ нь зөвхөн тухайн хуудаснуудын зохиогч нарын хариуцлага байх болно. Сэтгүүлийн нийтлэл, фотозураг, үзүүлэнгүүд нь илэрхий зохиогчийн эрхийн хязгаарлалттай бол сэтгүүлд дурдсан зохиогчоос зөвшөөрлийг нь авах шаардлагатай бөгөөд бусад тохиолдолд тэдгээрийг АНУ-аас бусад улсуудад орчуулж, дахин хуулбарлан олшруулж болно.

Олон Улсын Мэдээллийн хөтөлбөрийн Товчоо нь сэтгүүлийн хамгийн сүүлийн болон түүний өмнөх дугааруудыг *http://www.america.gov/publications/ejournalusa.html* хуудсан дээр төрөл бүрийн форматаар хадгалдаг. Та санал, бодлоо оршин байгаа улс дахь АНУ-ын Элчин сайдын яам эсхүл сэтгүүлийн зөвлөлд ирүүлж болно.

Эрхлэгч, eJournal USA
Америкийн Нэгдсэн Улс
Вашингтон, Колумби Дүүрэг 20522-0501
NW, С гудамжны 2200
АНУ-ын Төрийн Департамент
1 дүгээр давхар, SA-5
IIP/PUBJ
И-мэйл: eJournalUSA@state.gov

About This Issue

Centuries before the Common Era, scholars traveled to Taxila, Pakistan, to study Buddhism. Greeks traveled to ancient Persia to study under Zoroaster. Romans studied the language and ways of the Greeks.

In this month of August, hundreds of thousands of students will follow a fine old tradition as they leave home to seek higher education in another land. Through the course of this coming year, more than 600,000 young people are expected to come to the United States alone to pursue some form of study. They will enter the country and find their ways to campuses scattered across the 50 states, to be welcomed by diverse academic communities.

At the same time, more than 200,000 American students will leave their country for study abroad. International education is an imperative for them, their families, and their schools, but it is also a matter of national policy. Advocacy of and support for international study programs has been a key element of U.S. foreign policy for decades. Restating its commitment to this endeavor just a few years ago, the U.S. Senate resolved that educating students internationally is an important way "to work toward a peaceful global society."

As international travel makes the world a smaller place, and a globalized economy makes business, commerce, and employment spill across national

THE 99 are copyright © 2009 Teshkeel Media Group

Уг асуудлын тухайд

Манай тооллоос өмнө Буддизмыг судлахаар эрдэмтэд Пакистаны Таксиларуу аялж, Грекүүд Зороастерт шавь орохоор эртний Персд ирж байжээ. Ромчууд Грекүүдийн хэл, амьдрах хэв маягыг судалж байв. Энэ наймдугаар сард олон мянган оюутнууд өөр өөр улс оронд дээд боловсрол эзэмшихээр гэр орноо орхин эртний энэхүү тогтсон замаар аялах болно. Ирэх жилийн хувьд гэхэд зөвхөн АНУ-д 600,000 гаруй залуучууд ямар нэгэн хэлбэрийн сургалтад оролцохоор ирэх юм. Тэд 50 муж улсуудаар нэг тархасан оюутны хотхонуудад ирж төрөл бүрийн сургалтын орчингуудтай танилцах юм.

Гэтэл энэ мөчид 200,000 америк оюутнууд гадаадад суралцахаар эх орноо орхин одох юм. Гадаадад боловсрол эзэмших нь эдгээр оюутнууд, тэдгээрийн гэр бүл, сургуулиудад чухал ач холбогдолтой төдийгүй улс орны бодлогын асуудал юм. Сүүлийн олон арван жилийн хугацаанд олон улсын сургалтын хөтөлбөрүүдийг зохион байгуулах асуудлыг урамшуулан дэмжих нь АНУ-ын гадаад бодлогын нэгэн чухал элемент байсаар ирсэн. Энэхүү хичээл зүтгэлээ бататган хэдхэн жилийн өмнө АНУ-ын сенат "энх тайванч даян дэлхийн хамтын нийгэмлэгийг бий болгох чиглэлээр ажиллах" чухал арга бол оюутнуудад гадаадад боловсрол эзэмшүүлэх явдал гэдгийг баталгаажуулж өгсөн.

Улс хоорондын аялал дэлхийг улам бүр жижигрүүлэн, даяарчлагдаж буй эдийн засаг, бизнес, худалдаа, хөдөлмөр эрхлэлтийг улс орны хил хязгаараас хамаарахгүй болгож буй энэ үед бусад улсын уламжлал, заншлын талаар мэдэж,

boundaries, it is increasingly evident that fluency in other languages and knowledge of other cultures are desirable skills for young people to develop.

While the global economic downturn may defer the dreams of some would-be international students in the short term, long-term trends show that increasing numbers of young people are enticed abroad to seek higher education. Almost double the number of students travel abroad for an education today as compared with 20 years ago. And while economic and security concerns imposed short-term declines in those coming to the United States in the past, the number of traveling students tends to drift back upward as normalcy returns. Clearly, the natural tendency for young people to look toward a distant horizon cannot be suppressed for long.

In this issue of eJournal USA, we meet young people in the midst of an international study experience. We meet others who are just beginning to absorb the lessons of their recent study abroad. Some not-so-young people reflect on their experiences in international study and explain how their lives were reshaped by the lessons and ideas they discovered far away from home. And parents describe how their children grow from the study-abroad experience to become bolder, brighter human beings.We also offer tips and guidance for the young reader who may close this book and decide that the next stage of learning lies abroad.

— The Editors

аливаа гадаад хэлээр чөлөөтэй ярих нь залуу хүмүүсийн хувьд хөгжин боловсроход чухал чадвар болох нь улам бүр тодорхой болж байна.

Хэдийгээр дэлхийн эдийн засгийн хямрал богино хугацаанд гадаадад суралцах хүсэлтэй оюутнуудын хүсэл мөрөөдөлд саад учруулж байж болох боловч удаан хугацааны хандлагаас харахад улам бүр олон залуучууд гадаадад дээд боловсрол эзэмших сонирхолтой болж байгаа нь тодорхой байна. 20 жилийн өмнөхтэй харьцуулахад гадаадад суралцах оюутнуудын тоо бараг нэг дахин нэмэгдсэн байгаа юм. Өнгөрсөн хугацаанд АНУ-д ирж суралцагчдын тооны хувьд эдийн засаг болон аюулгүй байдлын улмаас богино хугацаанд бууралт харагдсан боловч байдал буцан хэвийн болох үед АНУ-д хүрэлцэн ирэгч оюутнуудын тоо эргэн нэмэгдэх хандлагатай байна. Залуу хүмүүсийн алсыг харах байгалын чиг хандлагыг удаан хугацаагаар дарах боломжгүй гэдэг нь тодорхой юм.

eJournal USA –ийн энэхүү дугаарт гадаадад суралцаж байгаа залуучуудтай уулзах болно. Түүнчлэн бид дөнгөж гадаадад ирээд шинэ хичээлээ үзэж суугаа хүмүүстэй ч уулзана. Зарим арай туршлагатай хүмүүс гадаадаас олж мэдсэн сургамж, санаа оноо нь хэрхэн тэдгээрийн амьдралд өөрчлөлт хийсэн талаараа тайлбарлаж, гадаадад суралцсан тухай туршлагаасаа хуваалцах болно. Түүнчлэн эцэг эхчүүд нь гадаадад суралцсан туршлага нь тэдгээрийг өсөж хөгжиж, илүү хал үзсэн, ухаалаг нэгэн болоход нь хэрхэн тус болсон талаар тайлбарлана. Бид мөн энэхүү номыг уншиж дуусаад дараагийн алхам маань гадаадад суралцах хэмээн шийдвэр гаргах залуучуудад заавар, зөвлөгөө өгөх болно.

—Эрхлэгчид

U.S. DEPARTMENT OF STATE / AUGUST 2009 / VOLUME 14 / NUMBER 8
http://www.america.gov/publications/ejournalusa.html

Campus Connections

What You'll Learn

10 Becoming a Cultural Broker
A Panel Discussion
Six international students at American University talk about their lives and experiences on a U.S. campus in Washington, D.C.

14 My Daughter Has Blossomed
Vikram Murthy, the Indian father of a student in the American University discussion, reflects on the decision to send his daughter to the United States for her education.

АНУ-ЫН ТӨРИЙН ДЕПАРТАМЕНТ / 2009 ОНЫ 8 ДУГААР САР / 14 ДЭХ ДЭВТЭР / ДУГААР 8
http://www.america.gov/publications/ejournalusa.html

Оюутны хотхон дахь холбоос

Та юуг сурч мэдэх вэ гэвэл

10 Уламжлал, заншлын зууч болох нь
Хэсгийн хэлэлцүүлэг
Америкийн Их сургуулийн гадаадын зургаан оюутан Вашингтон Д.С дэх АНУ-ын оюутны хотхон дахь амьдрал, туршлагынхаа талаар ярьж байна.

14 Миний охин цэцэглэн хөгжсөн
Америкийн Их сургуулийн хэлэлцүүлэг дээр энэтхэг оюутны аав Викрам Мэрти охиноо боловсрол эзэмшүүлэхээр АНУ-д илгээх шийдвэр гаргаж байснаа дурсан ярьж байна.

20 Гадаад оюутнуудын гэр бүл
1970-аад оны солилцооны оюутан Шри Ланк аав Мангала П.Б.Яапа өөрийн туршлагаа 2000-аад оны үед Америкийн Их сургуульд суралцаж байсан охиныхтойгоо харьцуулан ярьж байна.

30 Шведэд зургаан жил
Шарлотт Вест

20 A Family of International Students
Sri Lankan father Mangala P.B. Yapa, an exchange student in the 1970s, contrasts his experience with that of his daughter at American University in the 2000s.

30 Six Years in Sweden
Charlotte West
An American goes to Sweden as an exchange student and finds her life's work.

34 Here I Am, a Young Tree
Najwa Nasr
A Lebanese linguistics professor explains how an exchange program to the United States led her to life-changing discoveries about earlier generations of Arab immigrants.

39 Hope and Friendship Take Over
Romain Vezirian
A French exchange student of Armenian heritage recalls how he overcame a legacy of prejudice during a semester spent on a university campus in Oklahoma.

44 Superheroes Arise From a Life in Two Nations
An Interview With Naif Al-Mutawa
A Kuwaiti psychologist's binational upbringing has led him to spread a message of diversity and understanding through the graphic novel series THE 99.

48 Writing for Tolerance
Naif Al-Mutawa's first writing project attempted to teach the youngest readers about accepting differences in others.

52 Chuck Norris and the Search to Find Myself
Meghan Loftus
A former American exchange student describes a semester in Spain when she learned about herself and what she shares with young people of other cultures.

57 My Journey to Harvard
Siyabulela Xuza
A South African student reveals how

Солилцооны оюутнаар Швед явж, амьдралынхаа ажлаа олсон америк оюутан.

34 Энэ бол би, залуухан мод
Нажва Наср
Ливаны хэл шинжлэлийн профессор АНУ-ын солилцооны хөтөлбөрт хамрагдсан нь хэрхэн түүнийг эртний үеийн арабын цагаачдын талаар нээлт хийхэд хүргэсэн талаар ярьж байна.

39 Итгэл найдвар, Нөхөрлөл ялан дийлдэг
Ромэйн Везирайн
Армяны өв уламжлал судлаач Францын солилцооны оюутан Оклахомагийн Их сургуулийн оюутны хотхонд өнгөрүүлсэн семестрийн үеэр өөрийн тогтсон үзэл бодлоо хэрхэн даван гарснаа өгүүлж байна.

44 Хоёр улс дахь амьдралаас шилдэг баатрууд төрдөг
Найф Ал-Мутаватай хийсэн ярилцлага
Кувейтын сэтгэлзүйч хоёр соёлоор хүмүүжсэн нь түүнийг зурагт тууж THE 99-ийн тусламжтайгаар ойлголцол, хүмүүсийн өөр өөр байдлыг бусдад ойлгуулахад хүргэсэн талаараа ярьж байна.

48 Хүлээцтэй байхын талаар бичих нь
Найф Ал-Мутавагийн анхны зохиол нь залуучуудад бусдын өөр байдлыг хүлээн зөвшөөрөх тухай сургажээ.

52 Чак Норрис ба өөрийгөө хайсан эрэл
Меган Лофтус
Америкийн солилцооны оюутан өөрийн талаар болон бусад орнуудын залуучуудтай юугаараа ижил болохоо ойлгож мэдсэн Испанид өнгөрүүлсэн семестрийнхээ тухай ярьж байна.

57 Харвард руу хийсэн миний аялал
Сиябулела Шуза
Өмнөд Африкийн оюутан ээжийнх нь гал тогооны өрөөн дэх шинжлэх ухааны туршилт түүний АНУ-д Харвардын Их сургуульд хүрэх замыг нь хэрхэн бий болгосон талаар ярьж байна.

ЭНЭ ЯАГААД ЧУХАЛ ВЭ

62 Олон улсын боловсролын тухай
Аллан Гүүдмэн, Олон улсын боловсролын институтын Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал.
Урьд өмнө байгаагүй олон тооны америк болон гадаад оюутнууд хилийн чанадад суралцахаар гэр орноо орхин явж байна.

a science experiment in his mother's kitchen helped pave the way to Harvard University in the United States.

Why It's Important

62 The Case for International Education
Allan Goodman, President and CEO, Institute of International Education
Record numbers of U.S. and international students are leaving their home countries to study abroad.

69 Passport to Success
Alumni of international study programs have achieved high levels of professional success.

73 Just the Facts
Basic statistics about foreign students and exchange visitors in the United States.

How It's Done

75 The Basics on U.S. Visas
Summarizes the basic steps to obtain a visa and corrects misconceptions about the process.

80 Social Networks and Study Abroad
Charlotte West
International students are using social networks to enhance their learning experience.

84 New Requirements at U.S. Borders
New requirements for U.S. citizens traveling in and out of the country are taking effect in 2009-2010.

86 Get Ready, Here You Go
Steps to prepare yourself for travel abroad.

91 Resource Guide
Books, reports, Web sites, and other reference material focused on international study.

69 Амжилтын үндэс
Гадаадад суралцах хөтөлбөрүүдийн төгсөгчид мэргэжлийн өндөр түвшний амжилтанд хүрсэн.

73 Баримт дурдахад
АНУ дахь гадаадын оюутнууд, солилцооны зочдийн талаархи ерөнхий статистик мэдээллүүд

ҮҮНИЙГ ХЭРХЭН ХИЙДЭГ ВЭ

75 АНУ-ын визийн талаарх ерөнхий ойлголт
Виз авах ерөнхий журмыг танилцуулж, энэ үйл ажиллагааны талаарх буруу ойлголтуудад залруулга өгнө.

80 Нөхөрлөлийн сүлжээ ба гадаадад суралцах тухай
Шарлотт Вест
Суралцах туршлагаа сайжруулахын тулд гадаадын оюутнууд нөхөрлөлийн сүлжээгээ ашиглаж байна.

84 АНУ-ын хил дээр тавигдаж буй шинэ шаардлагууд
АНУ-ын иргэдийн эх орноосоо гарч явах болон буцан ирэхтэй холбоотой шинэ журмууд 2009-2010 онд хүчин төгөлдөр болж байна.

86 Бэлтгэ, Замдаа гар
Гадаадруу аялахдаа өөрийгөө бэлтгэх алхамууд.

91 Эх сурвалжууд
Гадаадад суралцахтай холбоотой ном, илтгэл, вэб хуудас, бусад лавлах материалууд.

What You'll Learn

Becoming a Cultural Broker

A Discussion With International Students at American University

An estimated 600,000 international students will take their places on campuses in the United States in the weeks to come as a new university term begins. Another 200,000 Americans will head in the opposite direction and leave the familiarity of their own country for an education in a different culture. In those hundreds of thousands of lives, no two experiences will be exactly alike. But when international students begin to share their stories, common themes emerge about what it is like to find a place in a new country on a strange campus. eJournal USA Managing Editor Charlene Porter shared a couple hours with just such a group on the campus of American University (A.U.) in Washington, D.C.:

- Akhmet Ishmukhamedov, Kazakhstan, 2009 Bachelor of Science, Political Science
- Shanika Yapa, Sri Lanka, Public Communications, undergraduate
- Gayatri Murthy, India, 2009 Master of Arts, International Communications
- Josй Henrнquez, El Salvador, 2009 Master of Arts, International Development
- Stephanie Ayeh, Ghana, Economics/International Studies, undergraduate
- Gihae Song, South Korea, Arts Management, master's degree candidate.

Та юуг сурч мэдэх вэ гэвэл

Уламжлал, заншлын зууч болох нь

Америкийн Их сургуулийн гадаадын оюутнуудтай хийсэн хэлэлцүүлэг

Ирэх долоо хоногуудад шинэ хичээлийн жил эхлэхэд ойролцоогоор 600,000 гаруй гадаадын оюутнууд АНУ-ын оюутны хотхонуудад хүрэлцэн ирэх гэж байна. Үүний зэрэгцээ 200,000 гаруй америк оюутнууд нөгөө чиглэлд буюу өөрийн эх орноо орхин бусад орнууд руу боловсрол эзэмшихээр явах юм. Энэ олон зуун мянган хүмүүсийн амьдралд эдгээр хоёр тохиолдол адилхан биш байх болно. Гэвч гадаадын оюутнууд өөрсөддөө тохиолдсон үйл явдлаа ярилцаж эхлэхэд шинэ улсад шинэхэн оюутны хотхонд өөрийн байраа олоход нь тэдэнд ижил асуудлууд тулгардаг нь нийтлэг. eJournal USA–ийн эрхлэгч Чарлин Портер Вашингтон Д.С дэх Америкийн Их сургуулийн оюутны хотхонд чухам ийм залуучуудтай хэдэн цаг байж ярилцав.

- Ахмет Ишмухамедов, Казахстан, 2009 оны Шинжлэх ухааны бакалавр, Улс төрийн шинжлэх ухаан
- Шаника Яапа, Шри Ланка, Олон нийтийн харилцаа
- Гаяатри Мэрти, Энэтхэг, 2009 оны Урлагын магистр, Олон улсын харилцаа холбоо
- Жөүз Хенрикүйз, Эл Сальватор, 2009 оны Урлагын магистр, Олон улсын хөгжил
- Стефани Ае, Гана, Эдийн засаг/Олон улс судлал
- Гиха Сонг, Өмнөд Солонгос, Урлагын менежмент, магистрийн зэрэг горлигч

Асуулт: Ахмет, Улс төрийн шинжлэх ухаанаар шинэхэн төгссөн оюутны хувьд энэ сэдвийг судлахад Вашингтон яагаад хамгийн тохиромжтой газар гэж бодсон бэ?

Ахмет: Үнэндээ би Казахстаны Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хөтөлбөр болох Болашакын хөтөлбөрийн хүрээнд суралцаж байсан. Намайг уг тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахаар өргөдлийн

Question: Akhmet, as a newly graduated student in political science, why did you think that Washington was the best place for you to study that subject?

Akhmet: Actually I was studying under the presidential scholarship program Bolashak from Kazakhstan. When I provided all of my application documents for the scholarship, the government decided which university, which city it was going to send me. After taking into account my specialization, public administration, it selected Washington, D.C., because it is a city where major government institutions are located. My documents were sent to American University because the scholarship administrators had previously sent students to this university who were interested in public administration. Furthermore, I was accepted to a highly ranked School of Public Affairs at American University. When I came here, I found that it was a great place to study and pursue my bachelor's degree in political science.

Courtesy of José Henriquez

José Henriquez (third from left) explored the Shenandoah Mountains with A.U. friends Paul Colombini, Brigitte Basile, and Xingni Liang.

Жөүз Хенрикүйз (зүүнээс гурав дах нь) Австрали андууд болох Паул Коломвини, Бригитти Базиле, Xingni Liang нарын хамт Шинандоа ууланд дээр байгаа нь.

материалаа бүрдүүлэн өгөхөд засгийн газраас намайг аль сургууль, аль хотод явуулахаа шийдвэрлэсэн. Миний мэргэшиж буй салбар болох төрийн удирдлагын асуудлыг харгалзан үзээд Вашингтон Д.С-г сонгосон. Яагаад гэвэл энд гол гол засгийн газрын институтууд оршдог. Тэтгэлэгт хөтөлбөрийн захиргаанаас урьд өмнө төрийн удирдлагын чиглэлээр сонирхон судалж байсан оюутнуудыг Америкийн Их сургуульд илгээж байсан учраас миний материалуудыг Америкийн Их сургуульд илгээсэн юм билээ. Түүнээс гадна, Америкийн Их сургууль дахь өндөр зэрэглэлтэй Төрийн албаны сургуульд намайг авахаар болсон. Энд ирээд би улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр суралцаж, бакалаврын зэрэг хамгаалахад үнэхээр сайхан газар болохыг мэдсэн.

Асуулт: Өнгөрсөн жил АНУ анхны Африк гаралтай ерөнхийлөгчөө сонгосон жил болж, сонгуулийн үеэрх улс төрийн үйл явдлуудыг Вашингтонд ажиглах боломжтой жил байсан. Эдгээр үйл явдлыг хэрхэн ажигласан талаараа яриач.

Ахмет: Энэ сонгуулийн үеэр би энд байсандаа үнэхээр баяртай байна. Хүмүүс маш их сэтгэл хөдөлсөн байгааг би мэдэрсэн. Тийм ч учраас бүх нийтийн сонгуульд маш олон сонгогчид оролцсон. Түүнээс гадна бүх нийтийн сонгуульд хэн ялахыг урьдчилан төсөөлөхөд хэцүү байсан. Жишээлбэл,

Q: The last year, a presidential election year, was quite a year to observe politics in Washington as the United States elected its first African-American president. Tell me about your observations of these events.

Akhmet: I am very glad that I was here at this elections. I observed how people were extremely excited about them. As a result, [there was] high voter turnout rate in general elections. Moreover, it was hard to predict who would win general elections. For example, last spring I asked one of my professors, "Who do you think will win, McCain or Obama?" He said, "Probably, it will be McCain." Then in October he said, "Probably Obama will win." When we were looking at primaries, caucuses, how politics works here — is very different from any country in the world.

Q: Shanika, you're a student of public communications, and certainly a lot of media issues were under debate during the presidential year. What were your observations?

Shanika: I think it came with a lot of positive and negative things. Like the debates being available, that was very useful. A friend of mine actually decided who she was going to vote for based on the debates, which I thought was really strange, but that was how she did it.

Q: Why did you think that was strange?

Shanika: Because I have noticed here at A.U. that people are either Democratic or Republican. They are very strong in their convictions, and there are very few people who are not strongly affiliated with either party.

Q: Your friend was different from other Americans you had observed, then?

Shanika: Yes. And I know she missed one debate, and it really helped her that she was able to watch it online later. But at the same time, I thought the media was biased towards the male candidates when compared to the female candidates. I'm minoring in women and gender studies so it matters, and I talked

би профессоруудынхаа нэгнээс "Маккэйн, Обама хоёрын хэн нь ялна гэж бодож байна?" гэж асуухад "Магадгүй, Маккэйн" гэж хэлж байсан боловч 10 дугаар сард "Магадгүй, Обама ялах байх" гэж хэлсэн. Энд хэрхэн улс төр явагддаг, сонгуулын сунгаа, фракцуудыг харахад дэлхийн бусад орнуудаас үнэхээр өөр харагддаг.

Асуулт: Шаника, чи олон нийтийн харилцааны чиглэлээр суралцдаг оюутан, мэдээж өнгөрсөн ерөнхийлөгчийн сонгуулийн жилийн турш хэвлэл мэдээллийн чиглэлээр маш олон асуудал хөндөгдсөн. Чиний ажиглалт юу байв?

Шаника: Мэдээж маш олон эерэг, сөрөг зүйлс байсан. Ялангуяа мэтгэлцээн байна гэдэг маш хэрэгтэй зүйл юм. Манай найз тэрхүү мэтгэлцээн дээр үндэслэн хэний төлөө санал өгөхөө шийдэж байсан. Миний хувьд бол энэ үнэхээр ер бусын хэрэг, гэхдээ л тэр саналаа тэгж өгсөн.

Асуулт: Яагаад тэгж сонгосон нь сонирхолтой байсан гэж?

Шаника: Би Америкийн Их сургууль дээр хүмүүс нэг бол Бүгд найрамдах эсхүл Ардчилсан намыг дэмждэг болохыг ажигласан. Тэд өөрсдийн үзэл бодолдоо хүчтэй итгэдэг, бас тэгээд аль нэг намд хүчтэй итгэл үнэмшилгүй хүмүүс маш цөөхөн байдаг юм билээ.

Асуулт: Тэгвэл таны найз бусад америкуудаас өөр байсан гэж ажигласан гэж үү?

Шаника: Харин тийм. Тэр нэг мэтгэлцээнийг үзэж чадаагүй ч дараа нь онлайнаар олж үзсэн нь түүнд үнэхээр нөлөөлсөн. Түүний зэрэгцээ хэвлэл мэдээлэл эмэгтэйчүүдийг бодвол эрэгтэй нэр дэвшигчдийг илүү дэмжиж байдаг юм байна гэж бодсон. Би эмэгтэйчүүд, хүйсийн асуудлыг нарийвчлан судалж байгаа учраас энэ надад чухал. Би хичээл дээрээ ч энэ асуудлаар нилээд ярьдаг. Гэтэл энэ бол үнэхээр шударга биш байсан. Би ингэж бодож байгаа олон хүмүүстэй санал нэг байсан. Ялангуяа, Сенаторч Хиллари Родхам Клинтон болон Амбан захирагч Сара Палин нартай хэвлэл мэдээлэл хэрхэн харилцаж байсныг жишээ болгон хэлж болно. Тэднийг эрэгтэй нэр дэвшигчдийг авч үзээгүйгээр илүү нарийвчлан ярьж байсан.

Гаяатри: Би 2007 оны 8 дугаар сард энд анх удаагаа ирсэн. Америкийн талаарх миний бодол бол нийтэд тарсан соёл заншил, утга зохиол, бас аавын минь надад ярьдаг байсан зүйлс байсан. Миний хувьд Америк гэдэг бол Саймон болон Гарфункел, эсхүл хүмүүс томоохон дэлгүүрээр алхаж яваа [Вашингтон Д.С дэх маш олон жагсаал цуглааны газар] хүмүүс байсан (инээв.). Манай аав тэгж хэлдэг байсан, харин миний эхний хичээлийн

about it quite a bit in my courses. That was really not fair. I felt I was in a majority who had a problem with that, and especially how Senator [Hillary Rodham] Clinton and Governor [Sarah] Palin were treated by the media. They were scrutinized in a way that the male candidates weren't.

Gayatri: When I came here in August 2007, it was the first time I had ever been here. My idea of America was popular culture and literature and what my dad would tell me. For me, my picture of America was Simon and Garfunkel and people marching on the Mall [a site of many demonstrations in Washington, D.C.]. (laughter) That was what my dad would tell me about, but my first semester didn't match up to that idealistic picture of America. Then I remember the spring semester of 2008, Obama came to A.U. and spoke, and that was the speech where he was endorsed by [U.S. Senator] Ted Kennedy, and it all happened here. My friends were saying, "We have to go!" I remember waking up at five in the morning and standing in line for that.

As a presidential candidate, Barack Obama greeted students at American University during a January 2008 campaign stop. Gayatri Murthy credits Obama's speech with showing her "the America that people imagined."

© AP Images/Charles Rex Arbogast

Ерөнхийлөгчид нэр дэвшигч Барак Обама 2008 оны нэгдүгээр сарын сурталчилгааны ажлын үеэрээ Америкийн Их сургууль дээр оюутнуудтай мэндчилэх үед. Гаяатри Мэрти "Хүмүүсийн төсөөлж байсан Америк" гэдгийг түүнд харуулсан Обамагийн илтгэлийг үнэлж байна.

семестрийн хувьд тийм ч бодож байсан шиг идиалны Америк дүр зурагтай минь нийцээгүй. Гэтэл 2008 оны хаврын семестрийн үеэр Обама Америкийн Их сургууль дээр ирж, илтгэл тавьсан нь үнэхээр АНУ-ын сенатор Тед Кеннеди ярьж байсантай агуулга нэг илтгэл байсан. Энэ бүхэн манай сургууль дээр болсон. Манай найзууд "Бид явах ёстой" гэж байсан. Би өглөө таван цагт босоод энэ илтгэлийг сонсохын тулд дараалалд зогсож байснаа санадаг юм.

Тэр үеэс эхлэн 2008 оны туршид би тэрхүү идиализмыг харж эхэлсэн юм. Та асуудлын аль ч өнцөгт байсан хамаагүй ярилцаж, анхаарал тавих зүйлс байсан. Миний хувьд хүмүүсийн мөрөөдөж байсан, ялангуяа манай аав, ээжийн үеийнхний мөрөөдөж байсан Америкийг тэгэхэд харж чадсан. Тэд Америкийг төсөөлж байхдаа Вьетнамын дайны эсрэг тэмцэл, 50-иад оны үеийн утга зохиол зэргийг харж байсан, Би ч тэдгээрийг харж байна. Харин тэр үеийнхтэй харьцуулахад илүү амьдаар нь.

Асуулт: Өглөөний таван цагт боссон тэр илтгэл тавьсан өдрийн талаар ариач. Найзууд чинь орноос чинь татан босгосон уу?

My Daughter Has Blossomed

Vikram Murthy

Vikram Murthy, the father of international student Gayatri Murthy on the American University panel, tells another side of the story about international education. Murthy is an electrical engineer who lives and works in Mumbai, India.

My wife and I both welcomed the idea when Gayatri told us she was determined to pursue a postgraduate education in the United States. We did not put up any resistance, but what did bother us were two things: How would we raise sufficient funds to finance her education in the United States, and how would Gayatri be able to live independently in a strange environment?

We were very fortunate in meeting and engaging a consultant in Mumbai who counseled us through some of those problems and set many of our apprehensions to rest. After meeting him, Gayatri, my wife, and I were able to go through the whole process with a relative degree of comfort and confidence. Later Gayatri won a prestigious scholarship to study at American University, so that eased our financial concerns and, of course, made us very proud.

When it came time to face the actual separation, my wife and I were certainly more nervous.

Gayatri had never lived away from home for the 22 years that she had spent with us in Mumbai. We were most apprehensive about Gayatri's first few weeks she would spend in Washington as we had no close acquaintances there to greet her or guide her or advise her. Gayatri was determined to travel alone, without either of us. In the end, she did locate a lady in Washington who was the sister of a close friend from India. This acquaintance received Gayatri and offered

Миний охин цэцэглэн хөгжсөн

Викрам Мэрти

Америкийн Их сургуулийн гадаадын оюутан Гаяатри Мэртигийн аав Викрам Мэрти гадаадын боловсролын талаар нөгөө өнцгөөс нь ярьж байна. Мэрти Энэтхэг улсын Мумбайд ажиллаж, амьдардаг цахилгааны инженер юм.

Гаяатриг АНУ-д магистрийн зэрэг хамгаалахаар суралцах шийдвэр гаргахад эхнэр бид хоёр хоёул дэмжсэн. Бид ямар нэг байдлаар эсэргүүцээгүй боловч хоёр зүйл бидний санааг зовоож байсан. Түүнийг АНУ-д суралцахад нь хангалттай санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн бий болгох вэ? Гаяатри тэс өөр орчинд хэрхэн бие дааж амьдарч чадах бол гэсэн асуудал байсан.

Мумбайд бидэнд эдгээр асуудлын талаар зөвлөж, санааг маань амраасан зөвлөхтэй уулзаж, ярилцсан нь их азтай явдал болсон. Түүнтэй уулзсаны дараа Гаяатри, эхнэр бид гурав харьцангуй итгэлтэй, боломжтой байдлаар бүх үйл явцыг эхнээс нь дуустал авч ярих боломжтой болсон юм. Дараа нь Гаяатри Америкийн Их сургуульд суралцах нэр хүндтэй тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан юм. Энэ бидний санхүүгийн эх үүсвэр бий болгох ачааллыг хөнгөвчилсөн төдийгүй бидэнд их бахархалтай байсан.

Яг түүнийг явах болоход эхнэр бид хоёр маш их сандарсан. 22 жилийн туршид бидэнтэй Мумбайд амьдрахдаа Гаяатри маань гэрээсээ хол хэзээ ч амьдарч байгаагүй. Ялангуяа Вашингтонд бидэнд таних, түүнийг тосч авах, туслах хүнгүй болохоор Вашингтонд байх түүний эхний хэдэн долоо хоногт бид хамгийн их санаа зовж байсан.

Бидний хэнийг ч авч явахгүй ганцаар явахаар Гаяатри шийдчихсэн байсан. Сүүлийн мөчид Гаяатри Энэтхэг дэх найзынхаа эгчийг Вашингтонд байдгийг олж мэдсэн юм. Тэр эгч нь Гаяатриг очиход хүлээн авч, хэдэн долоо хоног түүнийг амьдрах газраа олох хүртэл нь гэртээ байлгасан юм.

Яг үнэндээ бол бид тусдаа байснаар эхнэр бид хоёрт ч, Гаяатрид ч хэцүү байсан. Бид ажлаасаа орой бүр гэртээ ирмэгцээ ганц охиноо байхгүйд их үгүйлдэг байсан, охин маань гэрийнхаа халуун

her a place to stay for a few weeks before she found her own residence.

In fairness I would say both we, the parents, and Gayatri suffered from the separation. We missed the presence of our only child each day in the evenings when we both returned from work, and she missed the warmth and comfort of home, as well as the familiarity and confidence of living in Mumbai.

Though we have missed her, my wife and I have seen a welcome change in Gayatri in the two years she has lived in the United States. She is so much more confident and articulate. She is able to take decisions in her personal and professional life with ease and without the need to consult us. She has become a center of conversation amongst most audiences and does it with great ease and flair — quite in contrast to her reticence and quiet nature as a child. A change in her personality began at St. Xavier's College in Mumbai, but she has blossomed in the U.S. environment.

Other parents might ask me if they should send their child to another country as we did. I don't have a straightforward answer. I believe that the background and adaptability of the child to an "alien" environment will depend a lot on his or her upbringing. A child from a semi-urban or rural background is going to find it harder than one brought up in cities where life is challenging and children learn to adapt more easily. The parents and their socioeconomic backgrounds will have a lot of influence on the child's adaptability to change also. The child's familiarity with the English language is another factor. This is natural to many Indian students who go to the United States, but not at all to others.

Notwithstanding all I have said, my advice to any parent from India is that an education abroad is an experience that will transform their child into a confident person who can live independently and take both personal and professional decisions to his or her benefit.

Vikram Murthy (right) says that studying in the United States has benefitted his daughter Gayatri.

Courtesy of Vikram Murthy/Photo by Narayan Raju

Түүний охин Гаяатри АНУ-д суралцсанаараа маш их ашиг тустай болсон гэж Викрам Мэрти (баруун талд нь) ярьж байна.

дулаан уур амьсгалыг төдийгүй Мумбайд амьдарч дассан орчин, ахуйгаа санадаг байсан.

Хэдийгээр эхнэр бид хоёр түүнийг санаж байсан ч түүний АНУ-д амьдарсан хоёр жилийн хугацаанд Гаяатрид сайхан өөрчлөлтүүд гарсаныг би мэдсэн. Тэр маш их итгэлтэй бас уран тодорхой ярьдаг болсон. Тэр бидэнтэй зөвлөлдөхгүйгээр өөрийн хувийн болон мэргэжлийн амьдралдаа шийдвэр гаргах чадвартай болсон. Түүнийг маш олон хүмүүс сонсдог болж, охин маань ч хүүхэд байхынх шигээ дуугүй, даруухантайгаа харьцуулахад маш хялбархан, тодорхой ярьдаг болсон. Мумбайд Сэйнт Хавиерийн коллежид суралцаж байхад түүний зан чанар өөрчлөгдөж эхэлсэн юм. Харин АНУ-ын орчинд очоод охин маань үнэхээр цэцэглэн хөгжсөн.

Бусад эцэг эхчүүд бидэн шиг охиноо гадаад орнууд руу явуулах хэрэгтэй юу гэж надаас асууж болох юм. Мэдээж надад шууд өгөх хариулт байхгүй. "Харь" орчинд тухайн хүүхдийн хэрхэн дасч зохицох нь түүнийг хэрхэн өсгөж хүмүүжүүлснээс их хамаардаг гэдэгт би итгэдэг. Хагас хотожсон эсхүл хөдөө нутгаас гаралтай хүүхдийн хувьд амьдралд сорилт ихтэй, хурдан сурч, дасах чадвар нь илүү хөгжсөн хотын хүүхэдтэй харьцуулахад илүү хүндрэлтэй учирдаг. Түүнчлэн эцэг эх, тэдний нийгэм-эдийн засгийн байдал нь хүүхдийн өөрчлөлтөд дасан зохицох байдалд маш их нөлөөтэй. Хүүхдийн англи хэлний мэдлэг хэр түвшинд байгаа нь бас нэг хүчин зүйл болно. Хэдийгээр олон Энэтхэг оюутнуудын хувьд АНУ-д суралцах нь хэвийн зүйл мэт боловч бусад маш олон оюутны хувьд энэ нь тийм хялбар зүйл биш юм.

Дээр хэлснийг үл тооцвол, энэтхэг эцэг эхчүүдэд өгөх миний зөвлөгөө бол гадаадад боловсрол эзэмшинэ гэдэг нь хүүхэд өөрийнхөө ашиг тусын тулд хувийн болон мэргэжлийн асуудлаараа бие даан шийдвэр гаргах, амьдрах чадвартай өөртөө итгэлтэй хүн болгон хувиргах туршлага юм гэж хэлмээр байна.

From that moment on, the rest of 2008, I could see that idealism. Whatever side of the spectrum you were on, people were talking and had things to care about. For me, I could see the America that people imagined, especially my parents' generation. When they imagine America, they imagine Vietnam War protests, Beat Generation poetry, and I could see that. It was just a little more alive.

Q: Tell us about that day of the speech at five in the morning. Were your friends dragging you out of bed?

Gayatri: No, I was, like, "This I want to see." Because I am studying international communications, I am impressed by someone who can speak well and communicate with a range of people. So I was interested, but it wasn't like I had to go. November 4th [the U.S. election day in 2008], I was excited. January 20th [Inauguration Day], I was excited. By that time, I thought, "I have to go. It would be stupid to miss this moment."

Q: Enough politics, let's talk about your academic experience. Gayatri, you're warmed up. Tell me about the differences in how classes are conducted in the United States and in India.

Gayatri: It depends on what you study, but to a large extent, classes are very top-down in India. The professor comes with a very fixed idea of what he or she has to cover in class. I went to a very big Jesuit college; each class had about 300 people in it. It was difficult to have a class discussion, and that leads to a level of indifference. And our system was all about exams in the end, like the British system. You sit in class all year, and one day at the end of the year you

Hailing from India's warm west coast, Gayatri Murthy (left) huddles with friends Shanti Shoji (top) and Maria Fiorio (right) on a snowy December day at American University.

Courtesy of Gayatri Murthy

Энэтхэгийн дулаахан баруун эргээс ирсэн Гаяатри Мэрти (зүүн талд нь) цастай 12 дугаар сарын өдөр Америкийн Их сургуульд найз Шанти Шожи (дээд талд нь), Мариа Фиорио (баруун талд нь) нартай тэврэлдэж байгаа нь.

Гаяатри: Үгүй, би "Энийг л үзэхийг хүсч байна" гэсэн байдалтай л байсан. Би олон улсын харилцаа холбоо судалж байсан болохоор сайн ярьж чаддаг, бас олон төрөл давхаргийн хүмүүстэй харилцаж чаддаг хүнийг хараад үнэхээр биширсэн. Тийм болохоор надад их сонирхолтой байсан, түүнээс биш би очих ёстой гэж албадаагүй. 11 дүгээр сарын 4 нд [2008 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр] миний сэтгэл үнэхээр хөөрсөн байсан. Бас 1 дүгээр сарын 20-ны өдөр ч гэсэн [Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр]. Тэр үед "Би заавал очих ёстой. Ийм мөчийг алдвал алдас болно" гэж бодож байсан.

Асуулт: Улс төрийн талаар хангалттай ярилцлаа. Одоо та нарын хичээл сургуулийн талаар ярилцья. Гаяатри чи нилээд ам нээчихлээ. Америк болон Энэтхэгт хэрхэн хичээл явуулдаг ялгааг ариач.

Гаяатри: Таны ямар сэдэв судалж байгаагаас шалтгаалах боловч дийлэнхидээ Энэтхэгт хичээлийг дээрээс доош чиглэсэн байдлаар явуулдаг. Профессор хичээлд юу заах талаар маш тодорхой бодолтойгоор ирдэг. Би нэг анги нь 300 хүүхэдтэй маш том Исусын коллежид суралцаж байсан. Ангийн хэлэлцүүлэг хийхэд их хэцүү, тийм болохоор сонирхол буурахад хүргэдэг байсан. Тэгээд бас манай систем гэдэг Британий системтэй адил болохоор эцсийн дүндээ хамгийн гол нь шалгалт, шүүлэг болдог. Бүтэн жилийн турш хичээлд суугаад жилийн эцэст нэг л өдөр сурсан бүх зүйлээ бүгдийг нь шалгуулах хэрэгтэй болно. Семестрийн бичгийн ажил, эсхүл илтгэл гэж юу ч байхгүй. Харин миний уран зохиолын анги нилээд хэлэлцүүлэг хийдэг, жижиг анги байсан.

Энд ирэхэд ялгаатай тал нь та босч өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, ангид гараа өргөх, бусдыг зөвшөөрөхгүй байхыг харин ч дэмждэг. Товчоор хэлэхэд "Миний дэлхийг үзэх үзэл өөр" гэдэг. Түүнээс бид бүгд суралцдаг, энэ л Америкийн сургалтын сайхан тал.

regurgitate everything you learned, and that's the end of it. No term papers, no presentations. The one exception, my literature class was more discussion oriented and smaller.

When I came here, the difference was that you are encouraged to give your opinion, to raise your hand in class and disagree. To say, "My world view is different." We all learn then, and so that's the beauty of the American classroom.

José: I agree. I studied in Guatemala, and it was very similar to what Gayatri described. Discussions were not really promoted, and sometimes professors used to show that they had the authority; to argue with them was risky. To me that was the main difference. I really loved the way we had discussions with multiple points of view in the international development program.

Q: For you personally, was it difficult to adjust to the different mode of conduct in classes?

José: The first semester it was difficult. I had some English, but we had to read hundreds and hundreds of pages in English, and I didn't have the speed-reading for that. And I didn't understand the dynamics of expressing a totally contrary point of view to a classmate or the professor, like saying, "I'm sorry, I don't agree on that." So it was a process of getting used to that.

Stephanie: It was definitely difficult in the beginning to get used to just jumping in. Sometimes I felt like people were just jumping in [the discussion] trying to show they were smart. That's where I had issues. Where is the line between respecting the professor and expressing your own views? Sometimes I feel that line is crossed. Even now, I'm in my final year, and I still find it difficult to just cut in like that.

Gihae: I totally agree. I thought that some of the students acted really rude to the professor. I thought the professor is here to act more like a facilitator than an instructor, without acting on a lot of authority.

Жөүз: Би ч гэсэн санал нэг байна. Би Гаяатригийн ярьсантай тун ижил нөхцөлд Гватемалд суралцаж байсан. Хэлэлцүүлгийг нэг их дэмжихгүй, зарим үед профессорууд эрх мэдэлтэй гэдгээ үзүүлдэг. Мэтгэлцэнэ гэдэг эрсдэл ихтэй. Миний хувьд гол ялгаа бол энэ л байна. Олон улсын хөгжлийн хөтөлбөрийн олон төрлийн үзэл бодолтой хүмүүс хэлэлцүүлэг хийж байгаа нь надад үнэхээр таалагдсан.

Асуулт: Чиний хувьд хичээлийг өөр байдлаар явуулдаг байдалд зохицоход хэцүү байсан уу?

Жөүз: Эхний семестр хэцүү байсан. Би тодорхой хэмжээгээр англи хэлтэй боловч өдөр бүр зуу зуун хуудсыг англи хэл дээр унших хэрэгтэй болсон. Гэтэл би хурдан унших чадварыг эзэмшээгүй байсан. "Намайг өршөөгөөрэй. Би наадахыг чинь зөвшөөрөхгүй байна" гэх зэргээр ангийнхандаа эсхүл профессортоо тэс өөр үзэл бодол илэрхийлэхийн ач холбогдлыг ойлгохгүй байсан. Түүнд дасах хэрэгтэй болсон.

Стефани: Үнэхээр эхний үед шууд л ярианд ороод ирдэг байдалд дасахад хэцүү байсан. Заримдаа би хүмүүс өөрсдөө ухаантайгаа харуулах гээд л ярианд оролцож байна гэж хүртэл боддог байсан. Надад энэ хэцүү байсан. Профессорыг хүндэтгэх болон өөрийн үзэл бодлоо илэрхийлэх хоёрын зааг хаана байна аа? Заримдаа тэр заагийг зөрчөөд байгаа санагддаг. Одоо ч гэсэн би төгсөх жилээ байгаа ч ийм байдлаар шууд ярианд таслаад ороод ирэх нь амаргүй л байдаг.

Гиха: Би зуун хувь зөвшөөрч байна. Зарим оюутнууд үнэхээр профессортой хүндэтгэлгүй харилцаж байна гэж боддог. Профессорууд энд эрх мэдлээ харуулах биш илүү зохицуулах, туслах үүрэгтэй гэж боддог.

Эхний жилдээ би маш их унших хэрэгтэй болсон. Миний уншаад ойлгосон зүйлс маань буруу биш байгаа гэж бодсоноос би ангид ярихаа больсон. Өөртөө бага зэрэг итгэлгүй болсон. Үүнийг харсан бусад ангийхан маань, зарим профессорууд намайг эсхүл юм уншаагүй, эсхүл тэдний яриад байгаа сэдвээр ямар ч санаа оноо, бодол байхгүй юм байна гэж ойлгоход хүрсэн. Энэ бол миний өссөн тогтсон уламжлал биш байсан. Ангид би сонсох ёстой байснаас ярих ёстой байгаагүй. Тийм болохоор эхний семестр үнэхээр хэцүү байсан.

Асуулт: Цаг хугацаа өнгөрөхөд та нар хичээлийн хэлэлцүүлэгт илүү идэвхитэй оролцдог болсон уу?

Гиха: Би одоо ч гэсэн чимээгүй л суудаг. Гэхдээ би шууд ярианд үсэрч орох ч юмуу, эсхүл чангаар ярих гэхээс илүү надад цаг өгч байгаарай, бас асуултанд хариулах боломжтой гэж

When I came here for the first semester, I had to do a lot of reading. I was afraid that my understanding of the reading might be wrong, so I stopped talking in the classroom. I lost some self-confidence then. That made other classmates and some professors think that I did not do the reading or that I don't have any thoughts or opinions on the topics they addressed. And it wasn't the culture that I was raised up. We had to listen, not talk, in the classroom. So the first semester was really hard.

Q: Did you become more active in the classroom discussion over time?

Gihae: I'm still quiet. But I began to talk with professors, saying if you can give me some time to talk, rather than me speaking up and jumping in, I can answer questions. I asked professors each time when the semester begins. They understood my culture differences, and when the chance was given I was prepared.

Q: Understanding language in the classroom is one thing, but understanding American students and how they talk and interact, that might have required even further adjustment for you. Did you find informal communication difficult among your peer group?

Gayatri: I grew up with English as my first language, so that was an immediate advantage. That culture shock didn't exist. I come from a big city, Bombay [Mumbai], so coming from a city of 20 million people, my idea of space is very different. We're just not used to it. Private space is nonexistent.

Space is a big thing [issue between people], and it even infiltrates the definition of friendship and your boundaries, what you can expect or not expect from a friend. Initially my gut reaction was, "I miss home. I can't call my friend at two in the morning and ask them for something." I was sad, and I would compare and contrast the two different places. Eventually, you reach a point where you see both cultures for what they are. You begin to see the societies as both an outsider and an insider. Here, I've become the Indian spokesperson. I go home and I'm the kid who came back from America who can tell us how they really are.

профессоруудад хэлдэг. Семестр эхлэх бүрт би профессоруудаас ингэж асуудаг. Тэд миний өссөн уламжлал, орчинг ойлгосон, тэгээд миний ярих цаг болоход би бэлэн байдаг.

Асуулт: Хичээлийн танхимд яриаг ойлгох гэдэг нэг зүйл, гэтэл Америк оюутнууд, тэд хоорондоо хэрхэн ярилцаж, харилцаж байгааг ойлгоход та нарт үүнээс ч хэцүү байж болох талтай. Найзуудтайгаа харилцах чөлөөт харилцаа та нарт хэцүү байсан уу?

Гаяатри: Би Англи хэлийг үндсэн хэлээ болгон ашиглаж өссөн болохоор энэ миний давуу тал байсан л даа. Тийм болохоор би соёлын өөрчлөлтийн цохилтыг мэдрээгүй. Би Бомбэй [Мумбай] гэж том хотоос ирсэн, тийм болохоор 20 сая гаруй хүнтэй хотын хүн орон зайн тухай өөр ойлголттой байдаг. Хувийн орон зай гэж ерөөсөө байхгүй, бид үүнд ердөө дасаагүй.

Somewhere over the course of that first year in Sweden, I began to settle in and realized that Stockholm was somewhere I might like to live. The chance to extend my time abroad was partly due to

талаар бүхнийг олж мэдсэн. Магадгүй илүү чухал нь би Швед хэл судалсан. Шведүүд англи хэлээр бараг л төрөлх хэл шигээ ярьдаг болохоор шведээр нэг ч үг мэдэхгүй байсан ч тэнд бүрэн ойлголцох боломжтой. Гэхдээ миний хувьд "зүгээр л өнгөрөөх" биш гадаадад байсан туршлага хуримтлуулахад хэл сурах нь их чухал байсан. Швед хэлээр ярина гэдэг надад хувийн болон мэргэжлийн хувьд хэд хэдэн боломжийг нээж өгсөн. Хувийн үүднээс гадаад хэл сурна гэдэг (зайлшгүй алдаа гаргах замаар) маш олон хүний хувьд боломжтой зүйл. Хэл сурна гэдэг нөгөө талаар ажил мэргэжлийн хувьд зөв алхам. Одоо ч гэсэн АНУ-д буцаж ирээд долоо хоногт нэг оройг Швед мэдээ, мэдээллийг Англи хэлрүү орчуулж өнгөрөөдөг. Энэ нь тодорхойгүй чөлөөт ажил мэргэжилтэй хүний хувьд тогтвортой орлогын нэг эх үүсвэр болдог. Тухайн хэлээр чөлөөтэй ярих чадвартай байх нь миний эргэн тойронд юу болж байгааг илүү сайн ойлгоход тусалсан. Энэ нь ч намайг үргэлжлүүлэн үлдэх шийдвэр гаргахад нөлөөлсөн зүйлсийн нэг байх. Чи хүмүүс эргэн тойронд чинь юу гэж ярьж байгааг ойлгоно. Метро доторхи яриа аль хэдийн хоосон шуугиан байх аа болино. Миний бодлоор энэ нь би энэ газрын нэг хэсэг гэсэн мэдрэмжийг төрүүлдэг байх.

Өг тэгээд ав

Шведэд байсан тэрхүү эхний жилийн хугацаанд би дасаж эхэлсэн, бас тэгээд Стокольм бол миний амьдрахыг хүсч болох газар юм байна гэдгийг ойлгосон. Гадаадад байх хугацаагаа сунгах боломж бол нэг талаас их сургуульдаа судалгааны туслахаар үргэлжлүүлэн ажиллах боломжтой байсан хэдий ч энэ бол түүнээс ч олон шалтгаантай. Жуулчнаас зочин, зочноос миний гэр минь болсон хотын оршин суугч болоход Шведыг би өөр нүдээр харж эхэлсэн.

Гэвч гадаадын иргэний хувьд үргэлж ямар нэг байдлаар гаднаас харсан хэвээр л байдаг. Би хэлийг нь сурсан, уламжлал, заншлыг нь ойлгох гэж чадах бүхнээ хийсэн боловч тодорхой хэмжээгээр энэ бол би өөрийн Америк уламжлал, заншлаараа түүнийг хүлээн авч байгаа ойлголт минь болохыг ойлгосон. Зарим заншлын хувьд миний зүгээс дасан зохицохыг шаардаж байхад зарим зүйлс нь цаг хугацаа өнгөрөхөд ач холбогдлоо алдаж байсан. Зарим зүйлийг тухайлбал, давсархаг амттай чихэрт дуртай байдал, эсхүл зарим хүмүүс таашаалтай гэж үздэг исгэсэн загас болох surstromming зэргийг Шведын онцлог гэж үздэг.

an opportunity to continue working at the university as a research assistant, but it was more than that. I started to see Sweden with different eyes as I made the transition from tourist to visitor to resident in the city that had become my home.

But at the same time, as a foreigner, you will always in some ways remain on the outside looking in. I learned the language and did my best to understand the customs and culture, but I also learned that how I perceived what I saw was a reflection of my own American culture. Some customs required adjustment on my part, other things became less important over time, and a few things I just considered to be Swedish idiosyncrasies, such as their affinity for salty licorice and surstrцmming, a fermented herring considered by some to be a delicacy.

Unfamiliar culinary habits aside, maybe being from somewhere else gives you the best of both worlds. Living abroad is both give and take — you bring some of the experience home with you, and leave a part of yourself there. I have developed a fondness for meatballs and lingonberry sauce (which is thankfully available at IKEA in Seattle!), but I also taught my Swedish friends about the joys of an American Thanksgiving meal, complete with roasted turkey and pumpkin pie.

I returned to the United States just a few months ago, and I'm still processing the implications of my homecoming. I'm not sure Alfred Nobel could have comprehended our current world where technology allows you to work from anywhere with an Internet connection, but I think he was correct on many levels when he said, "Home is where I work, and I work everywhere."

Studying, living, and working in another country for the last six years has certainly expanded my notion of "home." No matter where I am, the land of IKEA, Volvo, cradle-to-grave welfare, minimalist design, and the Nobel Prizes will always feel a little bit like home.

Courtesy of Charlotte West/Photo by Alexander Mitelman

Charlotte encountered new and different culture and customs abroad, like a stroll across a frozen lake.

Нуурын мөсөн дээр хөндлөн гулд хэсүүчилэх мэт Шарлот шинэ соёл, зан заншилтай тулгарчээ.

Танил биш хооллох зуршил магадгүй аливаа нутгийн хамгийн сайхныг мэдрүүлж болох юм. Гадаадад амьдрана гэдэг өгч, авахыг багтаана. Чи өөрийн зарим хэсгээ тэр газартаа орхиод явна бас гэр лүүгээ зарим туршлагаа авч очино. Би бөөрөнхий мах болон лингонберри соусанд дуртай болсон (IKEA-гийн ачаар Сиатльд байдаг) боловч Швед найзууддаа Америк талархалын баярын шарсан цацагт хяруул, хулууны бялуу зэргийг зааж өгсөн.

Хэдхэн сарын өмнө би АНУ-д буцаж ирсэн, тэгээд гэртээ ирсэн ч явсан аялалын тухайгаа бодсоор л байна. Би Альфред Нобел технологийн тусламжтайгаар интернэтээр дамжуулан хаанаас ч ажиллаж болдог өнөөгийн ертөнцийг ойлгох байсан эсэхийг мэдэхгүй ч ямар ч байсан тэр "Гэр маань миний ажилладаг газар, би хаа сайгүй ажилладаг" гэж хэлсэн нь зөв санагддаг.

Сүүлийн зургаан жил гадаадад сурч, амьдарч ажилласан маань яах аргагүй "гэр" гэдэг ойлголтыг маань өргөжүүлсэн. Би хаана ч байсан IKEA, Волво, байнгын нийгмийн халамж, авсаархан загварууд, Нобелийн шагналын эх орон гэр шиг минь санагдах болно.

Here I Am, a Young Tree

Najwa Nasr

Najwa Nasr came to the United States from Lebanon in 1981, believing that she was coming to a strange country alone to pursue an advanced degree in her chosen field of linguistics. As the years went on, she found she wasn't building her own bridge to this new land, as much as she was crossing one erected by her countrymen generations before. Professor Nasr now teaches English linguistics at the Lebanese University. She received her PhD in that field from Georgetown University in Washington, D.C.

The experience in international exchange that has had the most profound effect on my life came after I completed my studies in 1986. I returned to Georgetown University in 1991 for three months of research in language and culture on a senior Fulbright grant I received through the Council for International Exchange of Scholars (CIES). During that period, I discovered the Naff Arab American Collection, which documents the heritage of early Arab, mainly Lebanese, immigrants to the United States.

Housed at the Smithsonian's National Museum of American History in Washington, the collection was donated to the museum by Alixa Naff in 1984 to honor her parents and their generation of immigrants. Naff, the author of Becoming American: The Early Arab Immigrant Experience, gave me a detailed and enthusiastic tour of the archives, housing personal photos, souvenirs, and artifacts donated to the collection.

I had been to many museums, but entering a museum archive requires a series of rituals. I had to sign my name and time of arrival. I was issued an

Энэ бол би, залуухан мод

Нажва Наср

Нажва Наср 1981 онд өөрийн сонгосон салбар болох хэл шинжлэлээр зэрэг хамгаалахаар үл мэдэх улсад ирж байна гэж итгэсээр Ливанаас АНУ-д иржээ. Жилийн хугацаа өнгөрөхөд тэрээр өөрийгөө энэ газарт анхны гүүрийг тавьж байгаа биш харин өөрийн өмнөх үе үеийн бий болгосон гүүрээр явж гарсан болохоо мэдсэн байна. Профессор Наср одоо Ливаны Их сургуульд Англи хэлний хэл зүй заадаг. Тэрээр энэ чиглэлээр докторын зэргээ Вашингтон дэх Жорж Тауны их сургуульд хамгаалж байжээ.

Миний амьдралд хамгийн том нөлөө үзүүлсэн гадаадад солилцоогоор байсан туршлага маань 1986 онд сургуулиа төгсөхөд эхэлсэн юм. 1991 онд би Олон улсын эрдэмтдийн солилцооны зөвлөлийн (CIES) шугамаар Фулбрайтын дээд шатны тэтгэлгээр Жорж Тауны их сургуульд буцан очиж 3 сарын хугацаанд хэл, заншлын талаар судалгаа хийсэн. Энэ хугацаанд би АНУ-д цагаачилсан эртний арабуудын, ялангуяа Ливанчуудын өв уламжлалыг баримтжуулсан Хуучны араб гаралтай америк цуглуулгыг олж нээсэн юм.

Вашингтон дахь Смитсоны Америкийн түүхийн үндэсний музейд байрлах цуглуулгыг 1984 онд Аликса Нафф эцэг эх, тэдний цагаач өвөг дээдсийг хүндэтгэн уг музейд хандивлажээ. Америк болох нь: Эртний араб цагаачдын амьдрал номыг зохиогч Нафф уг цуглуулгад хандивласан архив, хувийн фото зургууд, сувинер, гар хийцийн зүйлсүүдтэй намайг нарийвчлан танилцуулан тайлбарлаж өгсөн юм.

Би хэдийгээр маш олон музей үзэж байсан боловч музейн архивт нэвтрэхийн тулд нилээдгүй олон шалгуур хангах хэрэгтэй болж билээ. Би өөрийн нэр болон ирсэн өдрөө тэмдэглэх хэрэгтэй болсон. Надад нэр бүхий нэвтрэх үнэмлэх бичиж өгсөний дараа архив руу доош бууж, дахин шалгуур хангахын тулд гарын үсэг зурж, түрүүвчээ хураалган аюулгүй байдлын хаалгаар орсон.

Аликса Нафф учир тоймгүй урт цуварсан ханыг бий болгох хананы шүүгээний төрөл бүрийн

identification badge and began the descent to the archive, only to encounter another ritual of signing in, relinquishing my purse, and passing through a security check.

Alixa Naff began my tour pointing to the different rows of boxes in a series of shelved stacks forming a complex maze! She pulled down a box and carried it to a desk. Wearing white gloves, she started going through the contents, showing me photos, printed documents, and handwritten personal letters. She told me how she had visited these people all over the United States, collecting historically valuable items given away with pleasure by people wanting to clean up their attics. She was kind enough to help me buy sample copies of some photos as well as photocopies of documents.

I returned home feeling that this collection should be more accessible to the public in Lebanon. It is our heritage buried away in boxes underground, accessible only to those who know where to look. Something had to be done, so I decided to take a proposal to Lebanon's minister of culture. I had a hard time trying to get an appointment, but I finally had an audience with his excellency. I showed him the sample copies and notes I had written, and fervently explained to him the importance of the collection and the importance of sharing this immigration history with the Lebanese people. He was convinced, but there were no funds to finance my trip. I arrived at a compromise, "Pay for my ticket, and I'll take care of other expenses."

Najwa Nasr discovered a little-known history of Lebanese immigration while visiting the United States on research exchange program.

Courtesy of Najwa Nasr

Нажва Наср АНУ-д судалгааны солилцооны хөтөлбөрөөр зочилж байхдаа Ливан цагаачдын бараг мэдэгдээгүй түүхийг нээсэн байна.

хайрцагнуудыг зааж миний аялалыг эхлүүлэв. Тэрээр хайрцгыг татан гаргаж ширээн дээр авчирав. Цагаан бээлий өмсөөд тэрээр надад фото зураг, хэвлэсэн баримтууд, гар бичгийн хувийн захидал зэргийг үзүүлэн доторхийг нь уудалж

эхэлсэн. Тэрээр надад хэлэхдээ АНУ даяар хэрэн явж дээврийн хонгилоо цэвэрлэхийг хүссэн эдгээр хүмүүстэй уулзахаар очиж түүхэн чухал зүйлсийг цуглуулж байснаа ярьсан. Тэр намайг зарим зурагны дээж хуулбар, материалуудын фото хуулбарыг худалдан авахад минь тусалж билээ.

Би гэртээ ирэхдээ энэ цуглуулгыг Ливанд нийтэд хүртээмжтэй байлгах хэрэгтэй гэсэн бодолтой ирсэн юм. Энэ бол хайрцганд газрын доор, зөвхөн юуг хаанаас олохоо мэддэг цөөхөн хүмүүс ордог газар дарагдан байгаа бидний өв уламжлал юм. Ямар нэг зүйл хийх хэрэгтэй байсан. Тэгээд би Ливаны соёлын сайдад санал бичихээр шийдсэн юм. Түүнтэй уулзах цаг авах нь надад их хүнрэлтэй байсан боловч эцэст нь түүнтэй уулзах боломж гарсан юм. Би түүнд бичсэн тэмдэглэл болон зарим нэг дээж хуулбарыг үзүүлэн, энэхүү цуглуулгын болон цагаачлалын түүхийг Ливаны ард түмэнтэй хуваалцахын чухлыг тайлбарласан. Тэрээр надад итгэсэн боловч миний аялалыг санхүүжүүлэх хөрөнгө байгаагүй. Би ч буулт хийж, "Миний билетийг л төлчих. Би бусад зардлаа хариуцья" гэхэд хүрсэн юм.

The Immigrants Speak

A few months later, I returned to Washington to visit the Naff Collection again. For 10 days, I shuttled to the archives with insatiable eagerness, and stayed from open until close. With awe, I held photographs of people of all ages and their personal letters. Early immigrants spoke to me through tape recordings. My heart leapt at hearing those shaking voices from the early 20th century. Tears rose at the photos of people through so many phases of their lives.

A girl in her Palm Sunday dress stood beside a candle taller than she was. A photo postcard had hand-lettered numbers on each person pictured, and on the back, the numbers referred to individuals' names — Theodora, a girl, and a boy, Roosevelt, both named evidently for a popular U.S. president of the era.

Those young men and women, now decades long dead, believed that America was the land of opportunity, freedom, and equality for all. They were mostly peddlers, a job that required no experience, no capital, and no advanced language skills. Daily contact with American citizens broadened the immigrants' knowledge of their new environment and facilitated the process of their assimilation.

Stories about their experiences on the road revealed that they suffered from scorching heat and biting frost. Their clothes became wet and rotten; they

Four children of Arab-American immigrants are seen in an early 20thcentury photograph. Standing behind is Edouard, and from left to right are Margaret, Roosevelt, and Theodora.

20-р зууны эхэн үеийн фото зураг дээрхи Араб гаралтай дөрвөн Америк цагаач хүүхдийн зураг. Хойд талд нь зогсож буй нь Эдюард, зүүнээс баруун тийш Маргарет, Рүүзвельт, Теодора.

Цагаачдын яриа

Хэдэн сарын дараа би Наффын цуглуулгад дахин очихын тулд Вашингтонд буцан ирсэн юм. 10 хоногийн турш би архиваар ухаангүй хэрэн хэсч, нээгдэхээс нь хаагдах хүртэл ажиллаж байсан. Би бүх насны хүмүүсийн фото зураг, хувийн захидлыг мэдэрч биширч байлаа. Дээр үеийн цагаачид хуурцагт бичлэгээрээ надад ярьж байлаа. 20 дугаар зууны эхэн үеийн эдгээр чичирсэн хоолойг сонсоод зүрх минь хүчтэй цохилж байв. Амьдралынхаа төрөл бүрийн үеүүдэд байгаа олон олон хүний фото зургийг хараад нулимс минь шархирч байлаа.

Палм ням гарагийн даашинзаа өмссөн охин өөрөөсөө өндөр лааны дэргэж зогсжээ. Фото ил захидал дээр зурагт гарсан хүн бүр дээр гараар дугаарлан бичиж, ард талд нь дугаар бүрийн хажууд хүмүүсийн нэрийг –Теодора, охин, хүү, Рүүзвельт гэж бичсэн нь аль аль нь тухайн үеийн АНУ-ын алдартай ерөнхийлөгч нарын нэрээр нэрлэгджээ.

Олон арван жилийн өмнө нас барсан тэр үеийн эдгээр залуухан залуучууд, бүсгүйчүүд Америкийг боломж завшаан, эрх чөлөө, бүгдийн тэгш эрхийн газар нутаг гэж итгэж байжээ. Тэдний дийлэнхи нь ямар нэг туршлага, хөрөнгө, чадвар шаардахгүй явуулын худалдаачин байсан. Америкийн иргэдтэй өдөр тутам харилцах нь цагаачдын шинэ орчингийн талаархи мэдлэгийг нь өргөжүүлэн, түүнд нэгдэх үйл явдлыг хөнгөвчилж байжээ.

Тэдэнд тохиолдсон түүхийг харахад тэд замдаа норж, муудсан хувцастай, өлсөж, цанган зүдэрч, шатам халуун, хөлдөм хүйтнийг туулан гарч байжээ. Тэд нээлттэй талд нойтон өвсөн дээр шөнийг өнгөрүүлж, саравч, модны мөчир дор

starved and were beaten with fatigue. They spent nights in the open, on wet grass, tied to tree branches, or in barns; they were attacked by robbers and bandits, and chased by wild beasts.

Yet the stories they left behind showed they survived and prospered. Bashara Forzley, a young immigrant who came to the United States without mother or father, wrote an autobiography detailing how he rose from peddling to big business.

A young Arab-American boy worked as a peddler in a wave of immigration to the United States a century ago.

Нэгэн зууны өмнө АНУ-д ирж байсан цагаачдын давалгааны үед явуулын худалдаачин хийж байсан залуухан Араб гаралтай Америк хүү.

хорогдон, дээрэмчин, тонуулчдын дайралтад өртөж, зэрлэг араатанд хөөгдөж байж.

Гэсэн хэдий ч тэдний ардаа үлдээсэн түүхэнд тэд энэ бүхнийг тэсч гарч, амжилт олж цэцэглэснийг харуулж байна. Аав, ээжгүйгээр АНУ-д ирсэн залуухан цагаач Башара Форзли хэрхэн явуулын худалдаачнаас томоохон бизнест орж амжилтанд хүрсэн тухайгаа нарийвчлан намтартаа бичсэн байдаг.

1920-иод оны үед эдгээр залуу цагаачдад хандаж Халил Гибраны хэлсэн үгийг би уншсан. Түүний үг өөрсдийн үндэсний онцлог болон шинэ иргэний

I read Khalil Gibran's address to those young immigrants back in the 1920s. His words will ever remain a valuable guidance for immigrants who oscillate the poles of their national identity and their new citizenship:

… I believe in you, and I believe in your destiny. I believe that you are contributors to this new civilization.

I believe you can say to the founders of this great nation. "Here I am, a youth, a young tree, whose roots were plucked from the hills of Lebanon, yet I am deeply rooted here, and I would be fruitful."

An Unfolding Story

Back home, with sample copies of photos and documents, my meeting with His Excellency Minister Michel Eddй was a celebration of my rediscovery of this little-known heritage of my people. By 1996, with

харьяаллын голд савлан яваа цагаачдад үнэтэй зөвлөгөө хэвээр үлдэх юм.

... Би та бүхэнд итгэж байна. Бас та бүхний зорилгод итгэж байна.

Энэхүү шинэ соёл иргэншилд та бүх хувь нэмрээ оруулна гэдэгт би итгэж байна.

Энэхүү агуу үндэстэнг бий болгогчдод "Ливаны толгодоос үрээ авсан боловч

Энэ газар гүнзгий суурьтай болсон, жимслэг залуу, залуухан мод би энд байна" гэж хэлж чадна гэдэгт би итгэлтэй байна.

Нээгдэж буй түүх

Фото зураг, баримт бичгүүдийн дээж хуулбартай гэртээ ирээд эрхэм сайд Мичел Эддетай хийсэн миний уулзалт ард түмнийхээ энэхүү бага танигдсан өв уламжлалыг дахин нээсний тэмдэглэл байлаа. 1996 он гэхэд яамны дэмжлэгээр Амьд гарахын төлөөх аян гэдэг нэрээр АНУ-д цагаачилсан эртний Ливан цагаачдын анхны фото зургийн үзэсгэлэнг миний бие хянан зохион байгуулсан юм. Бэйрут хотын төвд зуу зуун хүмүүс үзэсгэлэнг үзэж, баримт бичиг, фото зургууд дээр бөөгнөрөн байсан юм. Хэн нэгэн өөрийн өвөг эцгийнхээ зургийг олж үзээд хөөрөн

ministry support, I supervised the first photo exhibit of early Lebanese immigrants to the United States, calling it A Journey of Survival. Hundreds visited the exhibit in downtown Beirut and swarmed around the photos and documents. Someone shouted with joy at discovering his grandfather's photo.

The effects of the event are still growing. A Journey of Survival is on the Internet (http:// www.salzburgseminar.org/ASC/csacl/ progs/ASC22/nasr/nasr.htm). People get in touch with me in search of their ancestors or seeking guidance on related research. I give slide lectures on early Lebanese immigrants to the United States. My ultimate goal of founding an immigration museum in Beirut has not been realized yet, but I have not given up.

My experience in international exchange began at Georgetown University more than 20 years ago, but has unfolded in more chapters than I ever could have known. Today, still growing from this experience, I find the roots go deeper still and the branches grow higher with healthy foliage and hearty fruit.

The poem by Khalil Gibran was written for the first edition of Syrian World magazine published in Brooklyn, New York, in 1926.

Both photos this page courtesy of Faris and Yamna Naff Arab American Collection, Archives Center, National Museum of American History, Smithsonian Institution.

хашхирч билээ.

Уг үйл явдлын үр дагавар улам бүр өргөжсөөр л байна. Амьд гарахын төлөөх аян одоо интернэт дээр бий (http://www.salzburgseminar.org/ASC/csacl/progs/ASC22/nasr/nasr.htm). Хүмүүс өөрсдийн өвөг дээдсээ хайж олох, холбогдох судалгааны талаар зөвлөгөө авахаар надтай холбогддог. Эртний Ливан цагаачдын талаар би АНУ-д лекц уншдаг. Бэйрутэд цагаачдын музейг үүсгэн бий болгох эцсийн зорилгыг хүмүүс ойлгоогүй л байна, гэхдээ би бууж өгөхгүй.

Миний гадаад солилцооны туршлага маань Жорж Таун их сургуульд 20 гаруй жилийн өмнө эхэлсэн, гэвч миний мэдэх боломжоос ч илүү хуудсыг надад нээж өгсөн юм. Өнөөдөр энэхүү туршлагаасаа өсч хөгжин, үндэс, язгуур нь улам бүр гүнзгийрэн, мөчир салаа нь эрүүл навч нахиа, арвин их жимсээр өндөрсөн ургасаар л байна.

Халил Гибраны шүлгийг 1926 онд Нью Йорк, Брүүклинд хэвлэгдсэн Сирийн Дэлхий сэтгүүлийн анхны дугаарт хэвлэсэн байна.

Энэхүү хуудасны зургуудыг Ститсоний Институтын Америкийн үндэсний түүхийн музейн Архивын төвийн Фарис, Яамна Наффын Араб-Америк цуглуулганаас авлаа.

Hope and Friendship Take Over

Romain Vezirian

A French college student of Armenian heritage arrives at the University of Oklahoma to discover he is sharing a room with another student who represents the traditional nemesis of his people. How he handles the moment changes his life. Romain Vezirian is a 26-year-old information manager for a communication agency in Paris. He spent a semester at the University of Oklahoma in 2005, and graduated from the Blaise Pascal University of Clermont- Ferrand in 2007.

This cannot be happening. This just can not be happening!

This was almost my first thought when I arrived at my new apartment on the campus of the University of Oklahoma, far different from what I had imagined. After all, I had been accepted for one semester, and the simple fact of being on campus was a dream come true for the young French student that I was. Everything was bigger, the girls were prettier, the people were more friendly. In short, I was in pretty high spirits when entering the door of my new apartment.

That changed fast.

I had agreed, mainly to save money, to share a room with another foreign student whom I knew nothing about. I was aware that he had arrived a day earlier, but the apartment was empty when I got there. I started unpacking and noticed that my roommate had left his passport on his desk.

"A quick look at it, just to know what he looks like," I thought. Next thing I knew, I had the passport in my hands, and what I saw did not please me at all. My roommate for the next semester would be Turkish. Not a big deal for many. But being half

Итгэл найдвар, Нөхөрлөл ялан дийлдэг

Ромэйн Везирайн

Францын Армений өв уламжлал судлалын оюутан Оклахомагийн Их сургуульд ирж, өөрийнх нь ард түмний уламжлалт дийлдэшгүй дайсны төлөөлөл болох өөр оюутантай нэг өрөөнд орох болсноо мэдэжээ. Энэ байдлыг хэрхэн зохицуулсан нь түүний амьдралыг өөрчилсөн байна. Ромэйн Везирайн Франц дахь холбооны агентлагийн 26 настай мэдээллийн менежер. Тэрээр 2005 онд нэг семестрийг Оклахомагийн их сургуульд өнгөрөөж, 2007 онд Клемонт-Феррандын Блэйз Паскалын Их сургуулийг төгссөн.

Ийм юм болно гэж байхгүй. Ийм юм болно гэж ерөөсөө л байх ёсгүй.

Миний төсөөлснөөс хамаагүй өөр санагдсан Оклахомагийн Их сургуулийн оюутны хотхонд шинэ байшиндаа орохоор ирэхэд хамгийн түрүүнд ийм бодол төрж байж билээ. Эцсийн эцэст би нэг семестр л сурах ёстой. Гэтэл залуухан Франц оюутан миний хувьд оюутны хотхонд байна гэдэг бол нөгөө мөрөөдөл биелэнэ гэдэг л байсан. Бүх зүйл илүү том, охидууд нь илүү хөөрхөн, хүмүүс нь илүү найрсаг гээд л. Товчоор хэлэхэд шинэ байрныхаа хаалгаар орж байхдаа сэтгэл санаа маш өндөр байсан.

Энэ байдал төдий л удаагүй.

Гол нь мөнгө хэмнэх үүднээс танихгүй бас гадаадын оюутантай нэг өрөөнд хамт орохыг зөвшөөрсөн юм. Би түүнийг надаас нэг өдрийн өмнө ирсэн гэдгийг мэдэж байсан боловч байранд намайг ороход хүн байсангүй. Би ачаа баглаагаа тайлж байхдаа өрөө нэгтэн маань ширээн дээр паспортаа орхиод явсаныг ажигласан юм.

"Ямархуу залуу байна гялс хараад орхиё" гэж бодов. Дараа нь нэг мэдэхэд паспортыг нь би барьчихсан зогсож байсан, юу харсан маань надад ерөөсөө таалагдаагүй. Ирэх нэг жилийн хугацаанд хамтран амьдрах хүн маань Турк байсан. Бусад хүмүүсийн хувьд нэг их сүртэй зүйл биш л дээ. Хагас Армен хүний хувьд надад шал өөр асуудал байв.

Турк, Армены түүх бол аймшигтай үйл явдлуудын цуврал юм. 1915-1917 оны хооронд болсон аллага бол улсын зүгээс зохион байгуулсан

Armenian, it made a huge difference to me.

The history between Turkey and Armenia is a series of awful events. The vast majority of Western historians have acknowledged that massacres between 1915 and 1917 were state-sponsored mass killings, more commonly known as the Armenian genocide. The Armenian diaspora has been campaigning for official recognition of the events as genocide for more than 30 years. In 1915, Ottoman authorities arrested some 250 Armenian intellectuals and community leaders in Constantinople. Thereafter, the Ottoman military uprooted Armenians from their homes and launched a campaign of forced marches and deportations ending with an estimated 1 million to 1.5 million deaths.

To this day, Turkey does not accept this recounting of the events, even though most genocide scholars and historians agree on this view. These same events forced my grandparents to leave their country. Both of my greatgrandfathers were killed.

Despite historical animosity between Armenians and Turks, Romain (left) "hit it off instantly" with his roommate and new best friend, Goko, when they met as exchange students.



Courtesy of Romain Vezirian

Турк, Арменчуудын түүхэн дайсагналыг эс тооцон, Ромэйн (зүүн талд) танилцсан шинэхэн сайн найз, "богино хугацаанд танилцсан" өрөөны хамтрагч Гокотой солилцооны оюутнууд байхдаа.

үй олноор хөнөөх, Арменыг төрлөөр нь устгах ажиллагаа байсан гэдгийг Барууны дийлэнхи түүхчид хүлээн зөвшөөрдөг. Эх нутгаасаа хол амьдарч буй Арменчууд сүүлийн 30 гаруй жил энэхүү үйл явдлыг төрлөөр нь устгах гэмт хэрэг байсан гэдгийг хүлээн зөвшөөрүүлэхийн тулд кампанит ажил явуулж байгаа юм. 1915 онд Оттоманы эрх мэдэлтнүүд Армены 250 оюунлаг сэхээтэн, нийгмийн удирдагчдийг Константинопольд баривчилсан. Түүний дараа Оттоманы цэргүүд Арменуудыг эх нутгаас нь үндсээр нь арчиж, хүчээр цөлсөн бөгөөд үүний үр дагавараар 1-1,5 сая хүмүүс амь үрэгдсэн юм.

Өнөөдөр хүртэл төрлөөр нь устгах асуудлаархи эрдэмтэд, түүхчид энэ асуудлыг зөвшөөрдөг хэдий ч Турк энэ үйл явдлыг дурдахыг ч зөвшөөрдөггүй юм. Энэ үйл явдлаас болж миний өвөг эцэг, эх эх орноо орхиход хүрсэн юм. Миний өвөг эцэг, эх хоёул алагдсан.

Gett ing Past Stereotypes

With this family history, I definitely had resentment toward the whole country, but having grown up in France, I had never really met a single person from Turkey. Now I was about to have to share my own room with one for a whole semester! Obviously, I was upset, but what could I do? Blatantly ignore him? Refuse to talk to him? Bearing a grudge would definitely ruin my plan for a fun semester in the United States. I decided I would give the guy a chance (his name was Goko) and see where it would lead. In retrospect, this was one of the best decisions I ever made.

I believe getting past stereotypes is one of the hardest things to do in life. But that's what happened in the first 10 minutes I talked to Goko. Against all odds, we hit it off instantly, and all the bad thoughts I had about Turkey and Turkish people were destroyed. I remember these moments so vividly, probably because they were my first step toward forgiveness. I was not very talkative at first, not wanting to lower my guard, but quickly realized it was no use fighting against good vibes and the beginning of a friendship. It was still a bittersweet feeling, because I could not stop wondering: "What would my grandparents think if they could see me right now?" Until I realized Goko was just a young student like me, enjoying life, and was more than happy to talk about our many common interests.

Romain today works in the communications industry in Paris.

Courtesy of Romain Vezirian



Өнөөдөр Ромэйн Парисын холбоо харилцааны салбарт ажилладаг.

Өнгөрсний талаархи үзэл бодолтойгоор тулгарах нь

Ийм гэр бүлээс гаралтайн хувьд надад яах аргагүй энэ улсын талаар бүхэлдээ дургүйцэл байдаг ч Францад өссөний хувьд Турк хүнтэй хэзээ ч танилцаж байгаагүй. Гэтэл одоо би бүхэл бүтэн нэг семестр өөрийн өрөөгөө ийм хүнтэй хуваалцах гэж байдаг. Үнэхээр миний сэтгэл гонсгор байсан боловч би юу хийж чадах вэ дээ? Зүгээр л түүнийг үл тоох уу? Түүнтэй ярихаас татгалзах уу? Жигшил зэвүүцэл дагуулах нь миний АНУ-д ирж нэг семестр сайхан байх төлөвлөгөөг минь мэдээж нураах болно. Би тэгээд түүнд (түүний нэрийг Гоко гэдэг) боломж олгохоор шийдэж, ер нь яахыг нь харахаар шийдсэн. Өнгөрсөн бүхнийг эргэн харахад энэ бол миний гаргасан хамгийн сайн шийдвэрүүдийн маань нэг байсан.

Өнгөрсөн буруу үзэл бодолтойгоо тулгарах гэдэг амьдралд тохиолдох хамгийн хэцүү зүйлийн нэг гэж би боддог. Ийм л байдал Гокотой ярилцах эхний 10 минутад болж өнгөрсөн юм даа. Хамгийн гайхалтай нь бид шууд л танилцсан юм. Турк улс болон Турк хүмүүсийн талаархи бүх муу бодол маань алга болсон. Би энэ мөчүүдийг маш сайн санадаг юм. Магадгүй энэ бүхэн өршөөх гэдэг талаар миний хийсэн анхны алхам ч байж болох юм. Эхэн үедээ би өөрийгөө хамгаалах гэж нэг их яриагүй. Гэвч маш хурдан сайн энергийн эсрэг, нөхөрлөл бий болохын эсрэг тэмцээд хэрэггүй болохыг ойлгосон. "Өвөг эцэг, эх маань яг одоо намайг харах юм бол юу гэж бодох бол?" гэж бодохгүй байж чаддаггүй учраас гашуун мэдрэмж одоо ч төрдөг. Гоко ч амьдралын сайхныг үзэх гэж буй над шиг залуухан оюутан гэдгийг ойлгосноос хойш бид нийтлэг сонирхолтой зүйлийнхээ талаар

He was also, obviously, not responsible for what previous generations had done before him. It almost sounds like a cheesy movie, but we became best friends and spent most of our free time together. I really cannot imagine what my semester at the University of Oklahoma would have been like without him.

Cherished Memories

When I look back on it, I remember the great teachers, the amazing facilities, the American friends I made, but what I cherish the most is my relationship with Goko and how much it changed me as a person. I now fully understand that ignorance causes wars and massacres like the one that took place in 1915. When people get together and try to understand each other's cultures and views, hope and friendship quickly take over.

I even became good friends with some other Turkish guys Goko introduced me to! If I had stayed in France, this would have never happened. If somebody had told me that I would become friends with a Turkish guy, I would never have believed them. I would just have stayed with my stupid ideas for the rest of my life. It was only one of many good experiences I had at the University of Oklahoma, but this one alone was worth the trip. It allowed me to become a more open-minded person, willing to get out of my comfort zone and meet different people. There is not only one right way of living or doing things, I learned, there are many. This is what makes our world so diverse and worth discovering.

I left the University of Oklahoma right before Christmas. Even if Goko, as a Muslim, does not celebrate Christmas, I wanted to get him a gift and found a t-shirt that I thought he would like. The funny thing is that he had the same idea, and actually bought me the exact same present! We ended up looking like

маш сайхан ярилцдаг болсон.

Мэдэжж өмнөх үеийнхэн түүнээс өмнө юу хийсэн талаар тэр хариуцлага хүлээх хүн биш байсан. Бараг л дургүй хүрмээр кино шиг үйл явдал байсан ч бид маш сайн найзууд болж, хамаг чөлөөт цагаа хамтдаа өнгөрөөсөн юм. Түүнгүйгээр Оклахомагийн Их сургууль дахь нэг семестр маань ямар байх байсныг үнэхээр төсөөлж чадахгүй байна.

Эргэн санагалзах дурсамжууд

Энэ бүхнийг эргэн санахад сайн багш нар, гайхалтай тэнхимүүд, найзалсан Америк нөхдүүд маань гээд санадаг боловч Гокотой нөхөрлөсөн нөхөрлөлөө бүр хамгийн их эргэн санагалздаг. Хүний минь хувьд энэ бүхэн намайг ямар их өөрчлөө вэ? Үл тоомсорлох гэдэг 1915 онд болсон шиг дайн, үй олноор алан хядах асуудлыг бий болгодог гэдгийг би бүрэн ойлгосон. Хүмүүс хамтарч, бие биенийхээ уламжлал, заншил, үзэл бодлыг ойлгох гэж оролдох юм бол итгэл найдвар, нөхөрлөл маш хурдан ялан дийлдэг.

Гокогийн танилцуулсан бусад зарим Турк залуучуудтай ч гэсэн би сайн найзууд болцгоосон. Хэрэв би Францдаа байсан бол ийм зүйл хэзээ ч болохгүй байсан юм. Хэрэв хэн нэгэн надад Турк найзтай болно гэж хэлсэн бол би хэзээ ч түүнд итгэхгүй байх байсан. Би өөрийн тэнэг үзэл бодолтойгоо бүх насаараа үлдэх байсан. Хэдийгээр энэ бол Оклахомагийн Их сургуульд өнгөрөөсөн миний маш олон сайхан дурсамжуудын маань нэг боловч зөвхөн энэ л үйл явдал энэхүү аялалыг маань ач холбогдолтой болсон гэдгийг дангаараа хангалттай харуулж чадаж байгаа юм. Энэ намайг илүү нээлттэй, өөрийн тухтай байдлын бүсээс гарч, өөр хүмүүстэй танилцахад бэлэн хүн болох боломжийг олгосон юм. Юмыг хийх, амьдрах ганц л зөв арга гэж байдаггүй, маш олон арга байдгийг би сурсан. Энэ л бидний дэлхийг ийм өвөрмөц болгож, нээн олборлох боломжийг олгож байгаа юм.

Оклахомагийн Их сургуулиас би яг Зул сарын баярын өмнө явсан. Лалын шашинтай хүний хувьд Гоко Зул сарыг тэмдэглэдэггүй ч би түүнд бэлэг авч өгөхийг хүсч, таалагдах байх гэж бодсон подволькоо худалдан авсан юм. Инээдтэй нь тэр бас яг тэгж бодоод надад яг ижил подвольк авсан

two idiots wearing the same clothes: one Turkish, one from Armenian descent, laughing just like two brothers.

Four years after their stay in Oklahoma, Romain and Goko still keep in touch. They plan on seeing each other again, whether in Paris or Istanbul.

байсан. Эцэст нь нэг Турк, нэг Армен гаралт хоёр яг ижил хувцас өмссөн хоёр тэнэг ах дүү шиг инээлдсээр үлдсэн дээ.

Оклахомад сурснаас хойш өнгөрсөн дөрвөн жилд одоо ч Ромэйн болон Гоко холбоотой байдаг. Парист ч юмуу эсхүл Истанбулд тэд дахин уулзахаар төлөвлөж байгаа юм билээ.

Superheroes Arise From a Life in Two Nations

An Interview With Naif Al-Mutawa

With advanced degrees in clinical psychology and business administration, plus experience in therapy, journalism, and literature, Naif Al-Mutawa has a varied and eclectic rüsumü. He earned his education in his native Kuwait and the United States, and continues to split his time between the two countries as he builds an international media company, Teshkeel Media Group.

The company has negotiated rights to distribute Arabic translations of many classic superhero comic characters born in the United States. Teshkeel took the exploits of Superman and Batman into the Middle East, but its flagship product is the graphic novel series THE 99. Launched in 2006, the story, written by Al-Mutawa and illustrated by an artistic team, is about a group of diverse, international characters that embody derivatives of the 99 attributes of Allah and Islam. In an interview with eJournal USA Managing Editor Charlene Porter, Al-Mutawa described how his bicultural upbringing and education brought him to the project.

Question: Describe your background in being raised in two nations.

Al-Mutawa: I grew up in Kuwait, born in 1971. I grew up spending summers in London to begin with, then Spain. When I turned eight, my parents decided they wanted me to have a U.S. background, so they sent me to a summer camp in New Hampshire [a northeastern U.S. state].

I grew up going to school in Kuwait and going to camp in New Hampshire. I became part of two worlds early on, at a time when there was no Internet, a

Супербаатарууд хоёр улс дахь амьдралаас төрдөг

Найф Аль-Мутава-тай хийсэн ярилцлага

Клиникийн сэтгэл судлал, бизнесийн удирдлагын чиглэлээр боловсролын өндөр зэрэгтэй, түүнчлэн, эмчилгээ зүй, сэтгүүл зүй, утга зохиолоор туршлагатай Найф Аль-Мутава өргөн, баялаг намтартай хүн. Тэр өөрийн төрлөх Кувейт болон АНУ-д боловсрол эзэмшсэн бөгөөд Тэшкээл Медиа групп олон улсын хэвлэл мэдээллийн компаниа байгуулахдаа энэ хоёр орны хооронд өөрийн цагаа зориулсаар иржээ.

Компани АНУ-д бий болсон олон сонгодог супербаатаруудын талаар араб хэлээр орчуулан гаргах эрхийг авчээ. Тэшкээл Суперман, Батмануудыг ойрхи дорнодод авчирсан төдийгүй тэдний хамгийн гол бүтээл нь THE 99 зурагт зохиолын цувралууд юм. Аль-Мутава бичиж, уран бүтээлчдийн багаас бүтээсэн 2006 онд бичигдсэн уг зохиолд Аллах болон Исламын 99 мөн чанарыг агуулсан олон улсын хэмжээний төрөл бүрийн баатрууд гардаг. eJournal USA-гийн Ерөнхий эрхлэгч Чарлин Портертай ярилцахдаа Ал-Мутава хоёр улсын соёл, боловсрол нь түүнийг хэрхэн ийм ажил хийхэд хүргэсэн талаар ярив.

Асуулт: Хоёр улсад өссөн талаараа ярьяач?

Аль-Мутава: Би 1971 онд Кувейтэд төрж, өссөн. Тэгээд би зундаа Лондонд байдаг байсан, дараа нь Испанид. Намайг 8 настай байхад аав, ээж маань намайг Америк боловсролтой болгохыг хүсч, Нью-Хамшир-т [АНУ-ын зүүн хойд хэсэгт орших муж] зуны сургалтад явуулсан.

Кувейтэд сургуульдаа явж, Нью-Хамшир-т зуны сургалтад явсаар өссөн. Их эрт буюу Интернет гэж байгаагүй, нөгөө улсын амьдрал өдөр тутмын харилцаа болоогүй тийм л үед би энэ хоёр улсын салшгүй хэсэг болсон. Одоо бол хэн ч Google эсхүл YouTube орж болж байна, дэлхийг үзэж болж байна. Гэтэл тэр үед бидэнд хиймэл дагуулын зурагт ч байгаагүй.

time when the experience of other worlds wasn't something that was transacted on a daily level. By now, anybody can go to Google and YouTube and see the world, but we didn't even have satellite television then.

So it gave me an early start trying to understand various concepts that didn't fit together properly to me, opinions regarding those who are "The Other," for instance. Everybody has that; whether you grew up in the States, Kuwait, or China, there is always a perception of The Other, the group of people who are different from your group. But I learned early on that who The Other was depended on where you were. That was an important education for me.

After high school, I went to university in the United States in Medford, Massachusetts, at Tufts University, which has a big, very diverse campus, and multiculturalism is a big theme of the education.

My first year at Tufts, 1990, I didn't have a country. Kuwait had been invaded, and my parents could not return home after their summer break. I didn't have a house then, but I had a home because I had an American family here whom I had gotten to

Энэ л надад тухайн үед ойлгоход амаргүй байсан төрөл бүрийн ойлголтуудыг тухайлбал "Тэд" гэж хэн болох тухай ойлголтуудыг ойлгоход тус болсон. Хүн бүр л АНУ-д байна уу, эсхүл Кувейт, бүр Хятадад ч байна уу өссөн байлаа гээд өөрийнх нь амьдардаг нийгмийн бүлгээс нь ялгаатай бүлэг байдгийг мэддэг. Гэвч Тэд гэдэг таны хаана байснаас хамаардаг гэдгийг би эрт ойлгож мэдсэн. Энэ бол надад их чухал хичээл байсан.

Дунд сургуулиа төгсөөд би АНУ-ын Массачусетсийн Медфорд дахь Тавтын Их сургуульд орсон. Энд маш том, олон улсын оюутнуудтай хотхонтой тэгээд ч олон соёл иргэншил гэдэг боловсролын том асуудал болдог.

1990 онд Тавтын их сургуульд эхний жилд байхад надад эх орон гэж байгаагүй. Кувейт эзлэгдсэн байсан. Ээж, аав маань зуны амралтынхаа дараа гэртээ очиж чадахгүй болсон. Тэр үед надад өөрийн гэсэн байшин ч байгаагүй. Харин Америкт сайн мэддэг болсон гэр бүлд өөрийн гэр шиг л байсан. Тэдний аав Лоренс Дурочер миний хувийн зөвлөх байсан харин өнөөдөр Тэшкээл-д

This caricature of Naif Al-Mutawa was drawn by the artistic team at the company he founded, Teshkeel Media Group.

Copyright © 2009 Teshkeel Media

Найф Аль-Мутава-гийн энэ хошин зургийг түүний үүсгэн байгуулсан Тэшкээл Медиа Групп-ийн уран бүтээлчид зуржээ. 2009 он, Тэшкээл Медиа-гийн зохиогчийн эрхтэй.

know very well. The father of that family, Lawrence Durocher, became my mentor and today works with me as my senior adviser at Teshkeel. He was the publisher of Rolling Stone magazine and a bunch of other stuff. So I was able to get to know people at a very intimate level. All those experiences fed back into what we are doing today.

Q: Expand on your comment earlier about The Other. How did you grapple with that during your years spent partly in Kuwait and partly in a New Hampshire camp. Were you trying to come to terms with two different definitions of The Other?

Al-Mutawa: Back in 1979, nobody knew where Kuwait was. In New Hampshire, I went to a predominantly Jewish summer camp. The kids were from Ohio and Pennsylvania, but there were no discussions about politics or religion or any of that. It was a comfortable environment to be in, and I was just the cute, chubby kid from a country that no one had heard of. I was different, but I never felt that I was The Other.

Q: But you still had awareness that the concept was a fixture in many social settings?

Al-Mutawa: As I grew up, absolutely. I made a lot of friends at camp, and because of the size of Kuwait and the politics of the region, certain stereotypes were passed as truths, and I was able to challenge those. These stereotypes largely revolved around demonizing The Other based on lack of interaction. In the case of the Arab-Israeli conflict, it's clear who The Other was growing up in my neck of the desert.

Q: You've made a very determined decision to make THE 99 into an international business enterprise. How did your background make that a compulsory decision for you?

Al-Mutawa: One of the main reasons I did THE 99 is that I'm a clinical psychologist. I'm licensed in New York State to practice. I trained at Bellevue Hospital's Survival of Political Torture Program. Because I speak Arabic, my patients came out of the Arab world, but there are people there from all over the world.

миний ахлах зөвлөхөөр ажилладаг. Тэр Rolling Stone сэтгүүл болон нилээд олон зүйлийг хэвлэн гаргадаг байсан. Тийм болохоор би хүмүүстэй маш ойрхон харьцах боломжтой байсан. Энэ бүхэн л бидний одоо юу хийж байгааг маань хийхэд хүргэсэн дээ.

Асуулт: "Тэд"-ний тухай ярьж байснаа дэлгэрүүлээч. Кувейт болон Нью-Хамшир-т зуны хотхонд байх жилүүддээ энэ асуудлыг яаж ойлгож байв? Таны хувьд хоёр өөр "Тэд" гэсэн ойлголтод хүрч байв уу?

Аль-Мутава: Тэр үед 1979 онд Кувейт хаана байдгийг хэн ч мэддэггүй байсан. Нью-Хамшир-т би Еврейчүүд олонхи нь болох зуны хотхонд байдаг байсан. Хүүхдүүд Охайо эсхүл Пеннсилваниагаас ирдэг байсан. Бид улс төр, шашин, тийм зүйлийн талаар ямар ч зүйл ярьдаггүй байсан. Тэр үед дотор нь байхад тааламжтай орчин байсан. Миний хувьд хэний ч сонсоогүй улсаас ирсэн хөөрхөн, цулцгар хүүхэд л байсан. Би бусдаас өөр байсан гэхдээ хэзээ ч өөрийгөө "Тэд"-ний нэг гэж мэдэрч байгаагүй.

Асуулт: Гэхдээ л та энэ ойлголт бол өөр өөр нийгэмд өөр өөр байдгийг мэддэг байсан.

Аль-Мутава: Мэдээж би өсөж том болох тусам зуны хотхонд олон найзтай болсон. Кувейт улсын хэмжээ, уг бүс нутгийн улс төрийн бодлогоос болоод зарим нэг буруу ойлголт үнэн юм шиг л яригдаж, би ч тэдгээртэй тэмцэж л байсан. Эдгээр буруу ойлголт нь харилцаа бага дээр үндэслэн "Тэд"-нийг шуламтай зүйрлэсэн л санаанууд. Араб-Израйлийн зөрчлийн хувьд бидний цөлийн хэсэгт хэнийг "Тэд" гэж ойлгох болсон нь тодорхой.

Асуулт: Та THE 99-ийг олон улсын бизнес болгох маш тодорхой шийдвэр гаргасан. Таны туршлага яаж таныг ийм шийдвэр гаргахад хүргэв ээ?

Аль-Мутава: THE 99-г хийх болсон нэг гол шалтгаан бол би клиникийн сэтгэл зүйч мэргэжилтэй хүн. Би Нью-Yорк мужид энэ чиглэлээр ажиллах лицензтэй. Би Беллевю Эмнэлгийн Улс төрийн тарчилгааныг даван туулах нь хөтөлбөрт суралцсан. Би Арабаар ярьдаг учраас миний өвчтөнүүдийн дийлэнхи нь Араб ертөнцөөс ирдэг ч тэнд дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүс ч байдаг.

Шоронд хоригдож байсан хүмүүсээс дандаа л сонсож байдаг нэг сэдэв бол тэд өөрсдийн удирдагч нараа баатар гэдгээр төсөөлөн өсч хүмүүжсэн болов ч эцэст нь өөрсдийнх нь баатарынх нь аппарат нь тэднийг тарчлаахыг үзэхэд хүрсэн байдаг. Энэ л намайг баатар гэж хэн

One of the resounding themes that I kept hearing from various ex-prisoners was a disappointment at a very deep and painful level of having grown up to consider their leader a hero, only to have that hero's apparatus torture them as adults. It got me thinking about what kind of message are we sending to our children about what a hero is, what a hero should be, what they should aspire to. So I knew that I wanted to create heroes for kids in that part of the world.

But I also knew that what I did had to have appeal in the West and in Asia also. I have heard and read about too many projects that left themselves vulnerable by only appealing to the Middle East market. In some cases, a single phone call from a dissatisfied person is all it takes to cancel a program. I knew that if I were to be involved in something like THE 99, I would pour my heart and soul into it. So I had to make sure it would have appeal on a global level.

So from Day One, I created the concept of 99 different heroes from 99 different countries. There are no religious overtones in the story. There's no proselytizing of any religion. The press picked up on this as a story about Islamic superheroes, and while it's inspired by Islam, there are other influences too. THE 99 refers to the 99 attributes of Allah referred to in the Quran, but the magic stones that give the 99 their superhero powers come from the collective wisdom of all religions and civilizations.

The story begins when the city of Baghdad fell to the forces of Hulagu Khan in 1258. The invaders want to destroy the progress of Islamic civilization, and so the caliph and the librarians of the legendary Dar al-Hikma scrambled to save and protect the collective wisdom of all religions stored in the library. So 99 gemstones are instilled with all the light of reason, and from those, these heroes draw their powers.

If I envisioned a global enterprise, I guess I wanted to create the sail and hold it up and wait for a gust that was going to take us across the Atlantic and Pacific, and thank God, we've been lucky in catching those breezes and turning this into a global enterprise.

бэ гэдэг талаар бид хүүхдүүддээ юу гэж хэлээд байдаг юм бэ? Тэд ямар болохыг хүсэх ёстой юм бэ гэдгийг бодоход хүргэсэн. Тэгээд би дэлхийн тэр нэг хэсэгт хүүхдүүдэд зориулан баатаруудыг бий болгохыг хүссэн юм.

Тэгээд бас миний хийсэн зүйл маань Баруунд болон Ази-д аль алинд нь нэр хүндтэй байх ёстой гэж бодсон. Зөвхөн Ойрхи дорнодын зах зээлд тохируулан хийснээр маш явцгүй болсон маш олон төслүүдийн талаар би сонсож, уншиж байсан. Зарим тохиолдолд сэтгэл ханамжгүй үлдсэн нэг хэрэглэгчээс л утсаар ярихад уг төслийг зогсооход ч хүрч байсан тохиолдол байсан. THE 99 шиг зүйлтэй холбогдох л юм бол би зүрх сэтгэлээ бүгдийг нь зориулна гэдгээ мэдэж байсан. Тийм болохоор миний хийж буй зүйл дэлхийн хэмжээнд сонирхолтой байх ёстой байсан.

Тэгээд эхний өдрөөсөө эхлээд 99 өөр улсаас 99 баатруудаа бүтээсэн. Энэ зохиолд шашныг магтан дуулсан агуулга байхгүй. Аливаа шашныг өнгөлөн далдалсан зүйл ч байхгүй. Хэвлэл мэдээлэл Исламын супербаатаруудын тухай зохиол гэж хүлээн авсан. Хэдийгээр Исламын нөлөө байсан боловч өөр нөлөөнүүд зөндөө бий. THE 99-д Коран сударт дурдсан байдаг Аллах-ын 99 мөн чанарыг дурддаг боловч 99-д супербаатарын хүчийг нь өгдөг шидэт чулуунууд нь бүхий л шашин, соёл иргэншилийн нэгдсэн оюун ухаанаас бий болсон ойлголт юм.

Зохиол маань 1258 онд Багдад хот Хүлэг хааны хүчинд сөхөрсөн байх үеэс эхэлдэг. Эзлэн түрэмгийлэгчид Исламын соёл иргэншлийн хөгжлийг устгахыг хүссэн, гэтэл домогт Дар Аль-Хикма-гийн халиф болон номын санчид номын санд байсан бүхий л шашны нэгдсэн оюун ухааныг аварч, хамгаалахын төлөө тэмцсэн байдаг. Тийм болохоор эдгээр баатруудын хүч чадлаа авдаг 99 эрдэнийн чулуунууд бүгд учир шалтгаантай нягт холбоотой.

Хэрэв би дэлхийн хэмжээний бизнестэй болно гэж төсөөлж байсан бол дарвуулаа хийгээд, өндөрт босгоод Атлант, Номхон далайг хөндлөн гулд авч гарах салхийг хүлээх байсан байх. Тэгээд энэ салхийг барьж, бизнесээ дэлхийн хэмжээнд хүргэсэндээ бурханд талархана.

Асуулт: Уран сайхны үүднээс THE 99 нь Америкийн супербаатарууд болон Азийн Покмон төрөл хоёроос үүсэлтэй. Таны хувьд зураач биш, гэтэл энэ хоёр уламжлалыг нийлүүлж хийнэ гэж бодож байсан уу?

Аль-Мутава: Тийм. Бизнесийн сургуульд байхдаа миний сурсан нэг зүйл бол хэрэв та шинэ

Writing for Tolerance

Naif Al-Mutawa began his writing career in children's literature more than a decade ago.

In a place called Bouncyland, everybody is round. In Bouncyland, the people who bounce the highest and roll the farthest are the most important, the best, and the most wonderful people. And it is only natural that this is so.

But then there was poor Bouncy Jr. He was born just a half circle. He could not bounce. He could not roll. Poor Bouncy. His parents were ashamed. He had no friends.

But one day a flood swept into Bouncyland. Even the bounciest and the rolliest were in danger. But Bouncy Jr was shaped like a boat, able to float across the raging waters and carry everyone to safety. And so the people of Bouncyland learn that there is more to life than bouncing and rolling.

That's how the tale goes in Naif Al-Mutawa's first book, To Bounce or Not to Bounce.

The brief, simply illustrated book is "what's become known as my first children's book," Al-Mutawa said, "but I didn't write it for children."

Al-Mutawa wrote the book when he was just 24 years old and a recent college graduate. He wrote it out of frustration in response to a story that was circulating in the Kuwaiti press at the time about a man who had been fired from his job because he was a follower of the Sikh religion. Equally maddening to Al-Mutawa was the employer's claim that had he known the fired employee was a Sikh, he never would have hired the fellow in the first place.

Хүлээцтэй байхын талаар бичих нь

Найф Аль-Мутава арав гаруй жилийн өмнөөс хүүхдийн зохиолын чиглэлээр дагнан зохиол бүтээл туурвиж эхэлжээ.

Баунсилэнд хэмээх ойдог газрын бүх хүн нь бөөрөнхий юм гэнэ. Тэр газарт хамгийн өндөр үсэрч, хамгийн хол өнхөрч чаддаг хүмүүс нь хамгийн чадвартай, хамгийн мундаг, хамгийн гайхалтайд тооцогддог гэнэ. Энд эрт урьд цагаас ийм байсаар ирсэн түүхтэй ажээ.

Харин тэнд бага Баунси хэмээх нэгэн өрөвдөлтэй хүү байж гэнэ. Тэр хүү эхээсээ тал дугуй хэлбэртэй төржээ. Тийм болохоор бусад шигээ ойж бууж чаддагггүй гэнэ. Хөөрхий амьтан. Эцэг эх нь хүүгээ ийм болж төрсөнд нь ичиж зовдог байжээ. Хүүд найз нөхөд ч байдаггүй гэнэ.

Нэг өдөр Баунсилэндэд үер болжээ. Хамгийн өндөр үсэрдэг, хамгийн хол өнхөрдөг мундаг хүүхдүүд хүртэл айж тэвджээ. Гэтэл бага Баунси хүү завь шиг хэлбэртэй болохоороо хүчтэй урсах усан дээгүүр хөвж, бүх хүнийг аюулгүй газарт хүргэж өгч чаджээ. Ийнхүү Баунсилэндийн оршин суугчид амьдралд өндөрт ойж үсрэх, хол өнхрөхөөс илүү чухал зүйл байдгийг ойлгож авчээ.

Энэ бол Найф Аль-Мутавагийн "Дээшээ үсрэх үү, болих уу?" хэмээх анхны номынх нь үлгэрийн үйл явдал.

Товчхон, энгийн зурагтай уг номыг "миний бичсэн анхны хүүхдийн ном гэдгээр олны танил болсон" хэмээн Аль-Мутава хэлээд "гэхдээ би энэ номыг уг нь хүүхэд багачуудад зориулж бичээгүй" гэсэн юм.

Аль-Мутава уг номыг дөнгөж 24 настай, коллеж төгсөөд удаагүй байхдаа бичжээ. Тухайн үед нэгэн залууг Сих шашны үзэлтэй байсных нь төлөө ажлаас нь халсан тухай Кувэйтийн сонин хэвлэлээр ид шуугиж байсан бөгөөд тэрээр үүний хариу болгож бухимдлаа илэрхийлж уг номыг бичсэн ажээ. Аль-Мутавагийн эгдүүцлийг төрүүлсэн өөр зүйл бол уг ажил олгогч ажлаас халагдсан тэр залууг Сих үзэлтэн гэдгийг мэдсэн бол анхнаасаа ажилд ч авахгүй байсан гэж мэдэгдсэн явдал юм.

It was the same era when Hutus and Tutsis were killing each other in Rwanda, and Serbs, Croats, and Bosnians were at war in the Balkans.

"For me that was all the same," Al-Mutawa said. "I wanted to write about it in a way that I would never have to write about it again." To Bounce or Not to Bounce went on to win an award from UNESCO for tolerance in children's literature. Al-Mutawa wrote a second book about the adventures of Bouncy Jr, but he left this career when he went back to university to pursue a doctorate in clinical psychology and a business degree. THE 99 marks Al- Mutawa's return to writing.

A page from Al-Mutawa's To Bounce or Not to Bounce, which won a UNESCO award for children's literature in the service of tolerance.

© Naif Al-Mutawa



Хүүхдийн уран зохиолд хүлээцтэй байхыг уриалсныхаа төлөө ЮНЕСКО-гийн шагнал хүртсэн Аль-Мутавагийн бичсэн "Дээшээ үсрэх үү, болих уу" номын хуудсаас.

Энэ бол Рванда улсад Хуту Туци нар бие биенээ хядаж, Балканы хойгт Серб, Хорват, Босни нар ид дайтаж байсан тэр цаг үед болсон явдал.

"Миний хувьд энэ бүгд ялгаагүй ав адилхан зүйл" хэмээн Аль-Мутава хэлээд "би энэ тухай ахиж хэзээ ч бичих шаардлагагүй болтол тийм арга замаар энэ тухай бичихийг зорьсон" гэлээ.

"Дээшээ үсрэх үү, болих уу" хэмээх ном хүүхдийн уран зохиолд хүлээцтэй байдлыг уриалсныхаа төлөө ЮНЕСКО-гийн шагнал хүртжээ. Аль-Мутава бага Баунси хүүгийн адал явдлын талаар хоёр дахь номоо бичсэн хэдий ч эмнэлгийн сэтгэл зүй болон бизнесийн зэрэг хэргэм горилон их сургуульд суралцах болсноор үзэг цаас нийлүүлэхээ хойш тавьжээ. "99" хэмээх ном нь Аль-Мутава ахин үзэг цаас нийлүүлэх болсныг харуулж байна.

Q: From an artistic standpoint, THE 99 has roots in both the American superhero comics and in the Asian animй, Pokйmon, type of characters. You are not the artist, but didn't you conceive of the incorporation of both artistic traditions?

Al-Mutawa: Yes. One of the things I learned in business school is that when you are developing a new product, you can't have too much that is "new" about it. If there's too much new about your product, you'll end up with a market of one, and that's you. I needed to find a medium that was accepted, and both the animй and the superhero comics are languages that have been spoken for decades. The concept of characters who are human and have superhero forms, that's a concept dating to the 1930s. Characters who work in teams — that's an Asian concept because they are group-oriented cultures. So the only thing new here is the archetype from which we derived the stories. I wanted this to be something that could stand on its own as a business, even though it has very clear social messages. I'm a big believer in the market.

Q: What are your aspirations for this graphic novel series and what it may teach world youth?

Al-Mutawa: I have aspirations on both a business level and a social level. On a business level, I want this to be a Disneyland type of company, and we see clear indications, Inshallah, that can happen. I see THE 99 taking their rightful place next to Superman, Batman, Spiderman, and Pokйmon, being ambassadors from our part of the world.

In terms of the message, there are a couple messages, one for the Western world and one for the Islamic world. The message for the Islamic world is: Enough, enough for not taking personal accountability and responsibility for what's going on in the world. All I hear about are people complaining that "there are people ruining our names" or that "we're being misrepresented in the press." Or I see reactive messages that come out of the reasoning, "Oh, they're making Arabs the bad guys? We'll do stories where the Americans are the bad guys."

бүтээгдэхүүн бий болгож буй бол дэндүү олон шинэ зүйл нэгэн зэрэг байж болохгүй. Хэрэв таны бүтээгдэхүүнд дэндүү олон шинэ зүйл байх юм бол таны зах зээл нэг хүнтэй л үлдэх болно. Тэр нь та өөрөө. Миний хувьд хүлээн зөвшөөрөгдсөн голын замыг олох хэрэгтэй байсан. Энд олон арван жилийн турш яригдсаар л ирсэн Покман болон супербаатарууд юм. Хүн мөртлөө супер баатарын хэвэнд ордог санаа бол аль 1930-аад оноос л эхлэлтэй. Багаар ажилладаг баатаруудын хувьд Азиас үүдэлтэй учир нь Азид бүлгээрээ амьдрах соёл илүү хөгжсөн.

Энд юу нь шинэ вэ гэвэл зохиолын маань үзүүлж буй үлгэр дууриал байгаа юм. Энэ зохиол маань нийгэмд маш ойлгомжтой асуудал дэвшүүлж байгаа хэдий ч би үүнийг биеэ даасан бизнес байлгахыг хүссэн. Би зах зээлд их итгэдэг шүү.

Асуулт: Та энэхүү цуврал зурагтай ном бичсэнээрээ юу хэлэх гэсэн бэ, энэ ном дэлхийн хүүхэд залууст юу зааж сургах вэ?

Аль-Мутава: Миний хувьд бизнесийн болон нийгмийн түвшинд аль алинд нь зорилго тавьж байгаа. Бизнесийн хувьд, би үүнийгээ Диснэйлэнд маягийн компани байгаасай гэж хүсдэг, Иншалла, энэ нь бүрэн боломжтой байгаа нь харагдсан. "99" ном маань Супермэн, Бэтмэн, Хүн аалз, Покемоны араас, лалын ертөнцийг төлөөлөн тэдний эгнээнд өөрийн гэсэн байр суурьиа эзлэнэ гэж бодож байна.

Нийгэмд дараах хоёр зүйлийг л хэлэх гээд байгаа юм, үүний нэгийг нь өрнийхэнд, нөгөөг нь лалын ертөнцөд хандаж хэлж байгаа юм. Лалын ертөнцөд хандаж юу хэлэх вэ гэхээр зэрэг дэлхий ертөнцөд болж байгаа бүхэнд хариуцлагагүй, ухамсаргүй хандаж ханалаа, одоо боллоо. Энд тэндээс хүмүүс надад хандаж "хүмүүс бидний нэр төрийг гутааж байна" гэх юм уу, эсвэл "хэвлэл мэдээллийнхэн бидний тухай буруу ташаа мэдээллээд байна" хэмээн цаг үргэлж гомдоллодог. Нөгөө нэг хэсэг нь болохоор бухимдлаа илэрхийлж "Арабуудыг өөдгүй амьтад гээд байна уу? Тэгвэл Америкуудыг өөрсдийг нь сонин хэвлэлээр гутаагаад өгье" гэх ч хүмүүс байна.

Лалын ертөнц дэхь хүмүүс одоо өөрсдийг нь дэлхий ертөнц хэрхэн хүлээж авч байгаад хувийн хариуцлага, ухамсартай хандах цаг болсон. Үүнийг би юуны өмнө үр хүүхдийнхээ тусын тулд хийж байгаа юм, гэхдээ би үүнийг хүн болгоны үр хүүхдэд зориулж хийж байгаа юм. Миний хүүхдүүд энэ дэлхий дээр дангаараа амьдрахгүй .

Лалын бус ертөнцийнхэнд:" Та минь ээ, энэ иргэншил хоорондын мөргөлдөөн, шашны дайны тухай хангалттай ярилаа, одоо боль" гэж хэлье.

It's time for people in the Islamic world to take personal responsibility and accountability for how we are being seen. I do this first and foremost for my children, but I do it for everybody's children. My children aren't going to live in the world alone.

The message to the non-Islamic world is: "Hey, this message about the clash of civilizations, the war of the religions — enough of that!" If you look at the core of the Islamic religion, the concepts in THE 99, the concepts of Allah and the Quran — generosity, wisdom, foresight, mercy — these are values shared by all civilizations. At the values levels, we're all the same.

The opinions expressed in this interview do not necessarily reflect the views or policies of the U.S. government.

Al-Mutawa created THE 99 for his children and everybody's children.

Ruth Fremson/The New York Times/Redux

Аль-Мутава "99" номоо өөрийн болон өрөөлийн бүх үр хүүхдэд зориулж бичжээ.

Лалын шашны уг үндсийг аваад үзэхэд, "99" гэдэг номын маань ойлголт санаа, Аллах тэнгэр, Коран судрын үзэл санаа цөм өглөгч байх, мэргэн ухаан, алсын хараатай байх, өршөөл нигүүлсэл үзүүлэх гэсэн л бүх соёл иргэншлийн хүлээн зөвшөөрсөн үнэт чанаруудыг агуулдаг. Үнэт чанарын хувьд хүн төрөлхтөн бид ижил чанаруудыг эрхэмлэдэг билээ.

Дээрхи ярилцлагад илэрхийлсэн үзэл санаа нь АНУ-ын Засгийн газрын үзэл бодлогыг тусгаагүй болно.

Chuck Norris and the Search to Find Myself

Meghan Loftus

A semester abroad is an opportunity to test who you are and what you can do, far away from the comforts of home and family. American Meghan Loftus graduated from Ithaca College in 2009 with a bachelor's degree in journalism and politics. She spent the spring of 2007 in Sevilla, Spain, attending the Center for Cross-Cultural Studies.

The cab dropped us off on a side street. I looked up at the gate, wondering what the next four months had in store. I was tired — jet lagged, yes, but also exhausted from listening to the Spanish flying around me and translating in my head … or trying anyway. I was only a day and a half into my semester abroad in Sevilla, Spain, and already it felt as if I had been there years. I was so exhausted I could have curled up on a street corner somewhere and fallen into a deep and restful sleep.

What was I doing here? I asked myself this as I stood waiting for my host mother to buzz us in to the apartment. It was the first of many times in the next four months that I would ask myself that question. Before my semester abroad, I had been out of the United States only a few times to visit Niagara Falls, Canada. I had never left North America. I had always wanted to travel abroad, especially in Spain. This was my dream! Why was I so nervous?

In moments like this, I was lucky that I had my friend Janelle. We each chose the same study-abroad program and were we glad we did. We had each other to share the many fun times. But in those nerve-wracking times, we always cheered each other up,

Чак Норрис ба өөрийгөө хайсан эрэл

Меган Лофтус

Хилийн чанадад нэг семестр суралцана гэдэг нь гэр орон, төрөл төрөгсдийнхээ нөмөр нөөлгөөс хол газар өөрийнхөө хэн болох, юу хийж чаддаг болохыг сорих боломж юм. Америк бүсгүй Меган Лофтус 2009 онд Итакагийн коллежийг сэтгүүл зүй, улс төрийн шинжлэх ухааны бакалаврын зэрэгтэй төгссөн. Тэрээр 2007 оны хавар Испаний Севилла хотын Соёл судлалын төвд суралцсан.

Такси биднийг хөл хөдөлгөөн багатай нэгэн нарийн гудамжинд буулгав. Би хашааны хаалгыг хальт харж, ирэх дөрвөн сар яажшуу өнгөрөх бол гэж бодож амжив. Би их ядарчээ – цагийн зөрөө гараагүй, бас хажуугаар нь онгоцонд хамт нисч явсан испани хүн надад орчуулж өгөхийг, орчуулах ч гэж дээ, орчуулахыг оролдохыг нь сонссоор бүр ядарч орхижээ. Хилийн чанадад Испанийн Севилла хотод нэг улирал суралцахаар ирээд дөнгөж нэг өдөр хагас хэртэй болж байгаа хэрнээ энд их удаан байсан шиг санагдах нь хачирхалтай. Ядарч туйлдсанаасаа болоод гудамжны хаа нэг буланд ч хамаагүй цагираглаж хэвтээд гүн, бат нойрсоход бэлэн байлаа.

Би энд юу хийж яваа юм бол? Намайг хүлээн авах испани ээж маань дотогш оруулахыг хүлээн зогсох зуураа өөрөөсөө ийнхүү асуулаа. Ирэх дөрвөн сарын хугацаанд өөрөөсөө энэ асуултыг олон удаа асуусны хамгийн эхнийх нь энэ байлаа. Гадаад явж суралцахаас өмнө би Канад дахь Ниагарагийн хүрхрээг үзэхийн тулд л цөөн хэдэн удаа АНУ-аас гадагш явж байсан. Би Хойд Америкаас ер явж үзээгүй. Би ямагт гадагш аялахыг, тэр дундаа Испанид очиж үзэхийг маш их хүсдэг байж билээ. Энэ чинь мөрөөдлийн маань нутаг шүү дээ. Би яагаад ингэтлээ сандарна вэ?

Аз болоход, иймэрхүү цаг мөчүүдэд Жанелл хэмээх найз маань хажууд хамт байдаг байсан. Бид хоёр хоёулаа гадаадад сурах ижил хөтөлбөрт хамрагдаж, ингэсэндээ ч хоёулаа баяртай байлаа. Бид хамтдаа олон баяртай мөчийг хамт өнгөрүүлсэн. Харин зарим бухимдмаар өдрүүдэд бид бие биенээ дэмжиж, тухайлбал Жанелл

like the time Janelle lost her backpack and half her clothes, or the times when I was terribly homesick. Through it all, we often had those moments where we couldn't believe our luck that we were spending a semester in a foreign country. What were we doing here?

Differences and Similarities

Over the course of the semester, I came up with many answers to my question. First, I wanted to see how people throughout the world lived their lives. I expected a lot of differences — what people ate, when

The author (right) and her friend Janelle Mackereth graduated from Ithaca College in 2009, two years after studying abroad together.

Courtesy of Meghan Loftus

Баруун гар талаас, зохиогч хилийн чанадад 2 жил хамт сурсан найз Жанелл Макеретийн хамт Итакагийн коллежийг төгсч буй нь, 2009 он.

үүргэвч, бас зарим хувцас хунараа алга болгоход нь юм уу, эсвэл би гэрээ маш их санах үед бие биедээ дэм болж чаддаг байв. Гэхдээ сайн өдрүүд нь хавьгүй олон байсан ба заримдаа харийн оронд ганц улирал суралцахаар ирсэн гэхэд итгэмээргүй азтай явдлууд тохиолддог байлаа. Бид энд юуны төлөө ирсэн бэ?

Ижил ба ялгаатай талууд

Нэг семестр суралцах хугацаанд би асуултандаа нэлээдгүй олон хариулт олж авсан. Юуны өмнө, дэлхийн газар газрын хүмүүс хэрхэн аж төрдгийг харах нь сонирхолтой байлаа. Хүмүүс юу идэж уудаг, хэдийд иддэг, юу өмсдөг, юунд дуртай зэрэг

they ate, how they dressed, what they liked — and I was right. In Sevilla, our biggest meal was at lunch, and we didn't eat dinner until midnight. And I always felt that my dressiest clothes were never dressy enough; other girls my age were always beautifully turned out, even if they were just headed to school.

But what surprised me were the similarities. Before I left home, I had been so focused on the differences I would encounter that I never thought about what I may have in common with people who live thousands of miles and an ocean away. We liked a lot of the same movies and music, had crushes on the same celebrities, and wanted the same things out of life, namely to love and be loved.

Then came the discussion of Chuck Norris's pushups changing the Earth's rotation. That joke came out of nowhere one night when Janelle and I were sitting with our Spanish friends at a tavern, attempting to translate between them and our friend Andrew. Down from London for a visit, Andrew spoke no Spanish, and only a few of our Spanish friends spoke English. So Janelle and I were having an interesting time translating and navigating the conversation when, somehow, Chuck Norris's name came up. The star of the U.S. television series Walker, Texas Ranger, Norris is the subject of many jokes attesting to his mythic powers of strength and kind of a cult figure in the United States.

Courtesy of Meghan Loftus

Meghan (bottom) and Janelle (top) strike a wacky pose as they explore the sights of Spain.

Испаний дурсгалт газруудаар зугаалж явахдаа авахуулсан зураг. Меган доод талд нь, Жанелл дээд талд нь.

олон зүйлээр ялгаатай байх болов уу гэж бодож байсан маань үнэн байсан. Севиллад гэхэд бид өдрийн цагаар хамгийн их хоол иддэг байсан ба оройн хоолоо шөнө дунд иддэг байв. Миний хамгийн ганган гэсэн хувцаснууд маань тийм ч ганган биш юм гэдгийг би ямагт мэдэрдэг байв, миний үеийн бусад охид сургуульд явахдаа хүртэл ямагт ганган хувцасладаг байсан.

Ижил талууд бас байсан нь гайхалтай санагдсан. Гэрээсээ явахаасаа өмнө би учирч болох ялгааны талаар бодож байснаас биш хэдэн мянган бээрийн цаана, тэнгис далайн нөгөө эрэг дэх хүмүүстэй адил төстэй чанар бий эсэх талаар огт бодож үзээгүй явлаа. Бид бүгд ижил дуу хөгжимд татагдаж, ижил оддыг шүтэж, амьдралаас нэгэн ижил зүйлийг, тухайлбал, хүнийг хайрлаж, хүнд хайрлагдахыг хүсч явдаг ажээ.

Тэгтэл Чак Норрис суниаснаас болж дэлхийн татах хүч өөрчлөгдөж байгаа тухай яриа болов. Жанелл бид хоёр нэг орой испани найзуудынхаа хамтаар цэнгээний газарт байх зуураа Андрю болон тэдний хооронд хэл залгуулах гэж оролдож байх зуур дээрхи наргиан гарч ирсэн. Лондонгоос ирээд байсан Андрю маань испаниар ярихгүй,

Our Spanish friends right away began making Chuck Norris jokes in both Spanish and English, telling us variations of the jokes that even we hadn't heard. Janelle, Andrew, and I were laughing hysterically. How could it be that here, in this tavern on a side street in Sevilla, we could be sharing jokes about Chuck Norris? In two languages, no less? It was a valuable lesson about the power of Chuck Norris as a cultural icon and an action-movie star, and, on a deeper level, how language is no barrier to sharing a good laugh.

Self-Revelations

Another reason I had come abroad was to learn about myself. You might think it's strange that I wanted to go somewhere different to learn about who I really am. But when I think about it, it makes perfect sense to me. When I was abroad, everything I encountered in my travels was new and unfamiliar. Each situation I walked into forced me to rethink what I knew about myself, about the situation, and about the options available in the moment. Whether it was running around in circles with Janelle in Barcelona trying to find the Sagrada Familia (hard to miss, but somehow we did), or realizing we had booked the wrong dates for a hostel on our spring break trip in Galway, Ireland, I had to react to stressful situations, which quickly became more stressful because I wasn't on my home turf. Still, I had to find my own solutions.

Guess what? We solved those problems without anxiety attacks (okay, maybe there were a few close calls). We eventually found the Sagrada Familia (even though we walked for miles), and we found another hostel in Ireland. We coped with events that might normally have made me freak out. But I learned from spending time in Sevilla, a place that values relaxation over stress, that these problems were all just part of the fun. Now I remember to prioritize the four F's — family, friends, fun, and food — instead

манай испани найзууд дунд англиар ярьдаг нь цөөхөн байсан юм. Тэгээд Жанелл бид хоёр ярриаг орчуулж, зуучлах гэж цагийг хөгжилтэй өнгөрүүлж байх зуур Чак Норрисын нэр гарч ирэх нь тэр. АНУ-ын телевизийн цуврал нэвтрүүлгүүд болох Уолкер, Техасын Рэнжэр зэрэг нэвтрүүлгийн од Чак Норрис үлгэр домгийн гэмээр хүч чадал, шүтэн бишрэгдсэн бие бялдартай болохоороо түүний тухай наргиан бишгүй их байдаг.

Испани найзууд маань тэр дороо л Чак Норрисын онигоонуудыг англи, испаниар дуржиганатал ярьж, бидний өөрсдийн ч огт дуулж мэдээгүй хувилбараар ярилаа. Жанелл, Андрю бид гурав ёстой элгээ хөштөл инээж билээ. Очиж очиж Севиллагийн нарийн гудамжин дахь бяцхан цэнгээний газар Чак Норрисын тухай онигоонуудыг испаниудтай яриад сууж байна гэхэд итгэмгүй. Тэгээд бүр ганц биш хоёр хэлээр шүү. Ийнхүү Чак Норрис бол шүтээн, адал явдалт киноны од болохын хувьд үнэхээр нөлөөтэй юм, бүр цаашилбал, хамтдаа инээлдэхэд хэлний бэрхшээл гэж байхгүй болох талаар мэдэж авсан.

Өөрийгөө нээсэн нь

Гадаадад ирсэн бас нэг шалтгаан бол өөрийгөө танин судлах явдал байсан юм. Өөрийгөө хэн болохыг танин мэдэхийн тулд хаа холын танихгүй хүний нутагт очихыг хүсдэг байсан гэвэл танд гайхалтай санагдах байх. Гэвч энэ тухай бодоод үзэхэд над маш ойлгомжтой байдаг. Гадаадад байхад зам зуур тохиолдсон бүх явдал шинэ, танил бус байсан. Надад тохиолдсон явдал бүхэн намайг өөрийнхөө тухай тухайн нөхцөл байдал, тухайн үед боломжийн арга замын талаар эргэцүүлэн бодоход хүргэж байсан. Барселонад Жанеллтай цуг Саграда Фамилиаг хайгаад (олж ядах юмгүй байсан ч бид будилсан шүү) явж байх үед, хаврын амралтаар Ирландын Гэлвэй явахдаа дэн буудлаа буруу өдөр захиалснаа олж мэдсэн зэрэг тулгамдсан үеүүдэд бухимдах, орон гэрээсээ хол явааг ч хэлэх үү, хэцүү санагдах үе байсан. Одоо ч гэсэн би өөрийн гэсэн шийд гарц хайх үе гарч ирдэг.

Харин бид яасан гээч? Бид эдгээр асуудлыг сандарч тэвдэлгүй давж гарсан, яах вэ, зарим үед гэр рүүгээ ойр ойрхон утсаар ярьж байсан үе бий. Бид тэгээд явсаар байгаад Саграда Фамилиаг олсон, ингэхийн тулд хэдэн миль газар алхсан ч гэсэн, бас Ирландад өөр дэн буудал ч олсон. Жирийн үед бол барьц алдуулж мэдэх эдгээр саадыг бид давж гарсан. Харин Севиллад байх хугацаандаа би стрессдэхээс илүүтэй амар тайванг эрхэмлэдэг энэ газар энэ зэргийн асуудал бол зугааны нэг хэлбэр гэдгийг ойлгосон. Одоо

of worrying about everything bad that can happen. I remind myself that, in the end, the little bumps in the road won't matter.

But on that first day in Sevilla, standing outside the gate waiting to get out of the rain, wondering how on earth I had gotten there, all of this remained before me. I often look back and see myself on that doorstep and whisper to the worrisome me: You're here because every day will be a new adventure.

би дөрвөн Чухлын зарчим буюу гэр бүл, найз нөхөд, зугаа цэнгэл, хоол хүнсийг дээдлэж, муу юм тохиолдож болно гэж зовохоо больсон. Эцсийн эцэст би өөртөө зам дээрхи бага зэргийн донсолгоо бол асуудал биш гэдгийг сануулдаг болсон.

Гэвч Севиллад ирсэн анхны өдрөө хашааны хаалганы гадаа бороо дуусахыг хүлээж зогсохдоо чухам яаж яваад энд ирээд байгаагаа гайхаж байсан маань ард үлджээ. Би болж өнгөрсөн бүхнийг эргэн дурсаж, хаалганы довжоон дээр зогсож буй өөрийгөө олж хардаг бөгөөд тэвдэн зогсож буй өөртөө хандан: Өдөр болгон шинэ адал явдал тохиолдох учраас л чи энд байгаа юм шүү гэж шивнэдэг билээ.

My Journey to Harvard

Siyabulela Xuza

A young man recalls how he has traveled from his South African township to Harvard University in Cambridge, Massachusetts. Science has been his ticket so far, and he hopes it will be his destiny. Siyabulela Xuza attended secondary school in South Africa and will begin his second year at Harvard in the final quarter of 2009. Xuza was a winner in the 58th Intel International Science and Engineering Fair.

I was chasing the roar of a Cessna plane dropping election pamphlets over Mthatha, my South African town. It was 1994, the first year of a new democracy in my country, and the sight of that technological marvel ignited in me a curiosity for science and a passion for using technology to engineer an African renaissance. That's what I'm working toward now as I study at Harvard University in the United States.

Soon after the day I saw that plane, I headed into Mom's kitchen and began mixing chemicals to make a new rocket fuel. I felt nervous of my mischievous deeds behind Mom's back, but the thrill of homemade chemistry was too much to resist. I loved my makeshift lab, equipped with Mother's utensils and smelling of a mixture of last night's dinner and the sweet scents of my chemicals.

It was paradise until one fateful day when I was absent-mindedly mixing up a new concoction. I forgot to turn down the stove setting, and the bubbly mixture changed to a hissing monster, spitting liquid all over the floor. What had been a spotless kitchen was suddenly covered in smoke and sticky rocket fuel. Mother charged into the room. I stuttered, my hands

Харвард руу хийсэн миний аялал

Сиябулела Шуза

Нэгэн залуу Өмнөд Африкийн жижигхэн хотоос Массачусетсийн Кэмбриж дэхь Харвардын Их сургуульд суралцах болсон түүхээ дурсаж байна. Эдүгээг хүртэл шинжлэх ухаан түүний зорчин явах тасалбар болж ирсэн ба цаашид ч хувь тавилан нь байх болно гэж тэр найдаж байна. Сиябулела Шуза Өмнөд Африкт дунд сургуульд сурч байсан бөгөөд 2009 оны намар Харвардад хоёр дугаар курсдээ элсэн суралцах юм. Шуза Интелийн Олон улсын Шинжлэх ухаан, Инженерчлэлийн 58 дахь удаагийн яармаг үзэсгэлэнгийн ялагч юм.

Би төрсөн нутаг Өмнөд Африкийн Мтатха хотын дээгүүр сонгуулийн сурталчилгааны хуудас цацаж явсан Сессна онгоцны араас гүйж байж билээ. Энэ бол 1994 онд болсон явдал бөгөөд эх оронд маань ардчилал анх удаа ялаад нэг жил болж байсан юм. Тэрхүү технологийн гайхамшгийг харсан минь шинжлэх ухааныг сонирхох миний сонирхлыг бадрааж, технологи ашиглан Африкийн цоо шинэ онгоц бүтээх чин хүсэл төрүүлсэн. Одоо би АНУ-д Харвардын их сургуульд энэ чиглэлээр суралцаж, зорилгодоо хүрэхээр хөдөлмөрлөж байна.

Тэр онгоцыг харсныхаа дараа би ээжийнхээ гал тогоонд орж, пуужингийн шинэ түлш гаргаж авахаар химийн элдэв бодисыг хутгаж эхэлсэн. Ээжээсээ нууж болчимгүй зүйл хийж байгаадаа эмээж байсан ч гэрийн нөхцөлд химийн бодис гаргаж авах тэр их таашаалын төлөө юу ч хийхэд бэлэн байв. Би ээжийнхээ гал тогооны хэрэгслүүдээр тоноглосон, урьд оройны хоолны үнэр шингэсэн түр орлуулагч лаборатори болон гаргаж авсан нялуун үнэртэй химийн бодисуудаа туйлаас дуртай байлаа.

Нэгэн бүтэлгүй өдөр шинэ холимог зуурч байхдаа болгоомж алдсан тэр мөч хүртэл бүх юм диваажинд байгаа мэт сайхан байсан юм. Би зуухныхаа тохируулгыг унтраахаа мартсанаас хөөсөрч байсан зуурмаг маань шажигнан дэвэрч, зуурмагийг маань шалаар нэлийтэл цацаж орхих нь тэр. Нэг ч толбогүй байсан гал тогоо маань яах ийхийн зуургүй утаа тортогт дарагдаж,

trembled, and I feared what was to come: the yelling of a lifetime.

My eardrums still rang from the scolding when I continued with the experiments, though more cautiously in the garage. What started as mischief grew into a serious four-year science project that I juggled with demanding school work, rugby games, theater productions, and community service.

We Have Lift-Off

Not only was I working on the fuel, but I was also building a rocket. That part of the project also tested my patience and commitment until one day in 2003 I began a nail-biting countdown to the launch of the experiment I'd named Phoenix. When I pressed the ignition button, a cloud of smoke shot down and the engine came to life like the sound of a thousand African drums. The Phoenix ascended majestically, cracking the sky, until it reached an altitude of 4,000 feet (1,220 meters). The successful launch was a testament to the value of perseverance.

I then entered the South African national science fair with a project entitled African Space: Fueling Africa's Quest to Space. The project was so well

Siyabulela Xuza's experiments propelled him from South Africa to Harvard, where he's pictured at the Barker Center for Humanities.

Courtesy of Siyabulela Xuza/Photo by Zach Rait

пуужингийн зууралданхай түлшээр хучигдав. Ээж ч хар хурдаараа гал тогоонд орж ирсэн. Би айсандаа ээрч, гар маань салгалж байсан ба үүнээс болж насан туршдаа загнуулж явах вий гэж эмээж байж билээ.

Үүнээс хойш ч туршилтаа үргэлжлүүлж, гаражид илүү болгоомжтой хийдэг болсон ч загнуулж байснаа бодохоор одоо ч чих хангинах шиг болдог. Зүггүйтэж эхэлсэн энэ ажил маань дөрвөн жил үргэлжлэх шинжлэх ухааны нухацтай төсөл болж хувирсан ба би үүнийгээ хичээл сургуулийн ачаалал, рагби тоглох, театрын бүтээл, олон нийтэд үзүүлэх үйлчилгээтэй зэрэгцүүлэн хийх болсон.

Сансарт хөөрсөн нь

Би зөвхөн түлш гаргаж авах гээд зогсоогүй пуужин хийж байсан юм. Фоеникс гэж нэрлэсэн туршилтаа эхлэхийг хүлээн амьсгаа даран тоолж байсан 2003 оны тэр нэг өдөр хүртэл энэхүү төсөл маань миний тэвчээр зүтгэлийг үнэнхүү шалгасан. Асаах товчлуурыг дарахад утаан үүл биднийг нөмрөн авч, мотор ажиллаж эхэлсэн нь Африкийн мянга мянган бөмбөр нүжигнэх мэт сонсогдож байж билээ. Фоеникс маань гайхалтай амжилттай хөөрч, тэнгэрийн гүнд зүсэх мэт орж, 4.000 фийт

Сияабулела Шуза хийж байсан туршилтуудынхаа ачаар Өмнөд Африкаас Харвардын их сургуульд ирж суралцсан ба Хүмүүнлэгийн төлөөх Баркерийн төвд зургаа авахуулсан байгаа нь.

буюу 1,220 метрийн өндөрт хүрсэн. Пуужин амжилттай хөөрсөн маань аливаа ажилд шургуу хандахын үнэ цэнийг ухааруулсан хэрэг болсон.

received that I was awarded two international trips — to the Nobel Prize ceremonies in Sweden and to the United States for an international science fair.

The international science fair, in Albuquerque, New Mexico, brought together more than 1,500 of the most innovative students from 52 countries to showcase their research and undergo a rigorous competition. I felt honored to represent my country and was enriched by the exchanges I had with students from all over the world. So after the judging was over, I headed off to the awards ceremony and took my seat, and I glanced around an immense auditorium, humming with keen anticipation. The event intimidated me, and I shrank into my seat as the grand award prizes were announced. "And the winner in the Energy and Transportation Category is Siya ..." the announcer shouted, only to be interrupted by a deafening applause. I had won a grand award as well as the honor of having a minor planet named after me.

On a Different Planet

The euphoria of my success at the international fair was the momentum that propelled me through my senior year, culminating in my acceptance to Harvard University. In the fall of 2008, I strolled into the lush yards and ivy-draped walls of Harvard to begin my freshman year. I had to adjust to a different education system where the process of reaching an answer is more valuable than the actual answer, and where collaboration and engaging with professors leads to higher

© Eskom Expo for Young Scientists

Siya explains his project to future scientists at the Intel International Science and Engineering Fair, where he won a grand award.

Сияа Интелийн Олон улсын шинжлэх ухаан, Залуу эрдэмтдийн Эском Экспо.инженерчлэлийн үзэсгэлэн яармагийн тэргүүн байрын шагналыг хүртсэн бөгөөд ирээдүйн эрдэмтдэд төслөө танилцуулж байгаа нь.

Дараагаар нь би Өмнөд Африкийн үндэсний шинжлэх ухааны яармаг үзэсгэлэнд "Африкийн огторгуй: Африкийг сансарт хөөргөх нь" гэдэг төслөөр оролцсон юм. Төслийг маань тун сайхан хүлээж авсан бөгөөд хилийн чанадад аялах хоёр урилгаар шагнуулж Шведэд Нобелийн шагнал гардуулах ёслолын ажиллагаанд оролцож, АНУ-д олон улсын шинжлэх ухааны үзэсгэлэн яармагт оролцох урилгаар шагнуулсан юм.

Шинэ Мексикийн Альбукеркү хотноо болсон олон улсын шинжэх ухааны үзэсгэлэнд 52 орны шинийг сэдэгч 1,500-гаад оюутнууд хүрэлцэн ирж, судалгаа бүтээлээ харуулж, ширүүн өрсөлдөөнд хүч оюунаа сорихоор иржээ. Би эх орноо төлөөлж орсондоо сэтгэл хангалуун байсан ба дэлхийн газар газраас ирсэн оюутнуудаас их зүйлийг олж мэдсэн. Шалгаруулалт явагдаж дууссаны дараа би шагнал гардуулах ёслолын ажиллагаанд орж суудлаа эзлээд эргэн тойронд байгаа үй олон хүнийг харж сэтгэл догдлон хариу хүлээлээ. Уг үйл ажиллагаа сүрдмээр байсан бөгөөд өөрийн эрхгүй сандалдаа шигдэн суух үед минь тэргүүн байрын эзнийг зарлалаа. "Эрчим хүч, тээврийн төрлийн шилдэг төслийн ялагчаар Сия..." хэмээн хөтлөгч чангаар зарлахад нижигнэсэн алга ташилт үгийг нь тасалдууллаа. Би тэргүүн байрын шагналыг аваад зогсохгүй нэгэн жижиг гаригийг нэрээр маань нэрлэсэн нь нэр хүндийн хэрэг байсан билээ.

Өөр тивд

Олон улсын үзэсгэлэн яармагт амжилттай оролцсон амжилтын маань дуулиан намайг төгсөх жил урам хайрлаж, улмаар Харвардын их сургуульд тэнцэх аз хайрласан юм. 2008 оны намар гэхэд өвс ногоогоор хучигдсан, гоёмсог мөлхөөгөөр чимэглэсэн ханаар хүрээлэгдсэн Харвардын их сургуульд шинэхэн оюутан болж

grades. I took intellectual risks by taking unfamiliar courses such as Mandarin, economics, and world music to broaden my mind and make me an interdisciplinary thinker.

Outside of the classroom, I joined the Harvard Forum for International Leadership. The society unites students from all around the world and facilitates panels on global terrorism, leadership, HIV/AIDS, technology, and African development. The forum also exposed me to the ever-increasing threat of climate change as demand for energy surges in both the developing and developed worlds. As great as this threat is, it is an opportunity to begin the clean-technology revolution.

Addressing climate change motivates my new passion: to use my experience working on new rocket fuels and my present resources at Harvard to develop next-generation automobile and jet fuels to mitigate the hazards of the climate crisis. I am now researching leading technologies in synthetic biology and renewable energy to foster sustainable African development and assist in igniting the intellectual potential of a continent that is yet to fulfill its promise.

The transition from my African roots into American society has exposed me to the value of our diverse cultures. I have been involved in many a late-night dorm debate on issues ranging from social justice to the ethics of genetics, and I have gained perspective on other students' points of views. Despite our differences, I learned that we all share the fundamental values of liberty and justice, values that can be achieved only through tolerance and a greater understanding of each other's cultures.

More mundane moments, such as the joy of my first snowfall, also marked my adjustment to America. I froze in the harsh northeastern winters and longed for the African sun, but my soul thawed from the warmth of the American people, whose kindness nurtured my evolution into a citizen of the world.

элсэн суралцсан. Энд би бодит хариултаас илүүтэй хариулт олж авах процесс нь илүү үнэ цэнэтэй байдаг боловсролын өөр системд дасах шаардлагатай болсон бөгөөд профессор багш нартайгаа хамтран ажиллаж хэл амаа ойлголцох нь илүү амжилттай сурах эх үндэс болдгийг мэдэж авсан. Би оюун ухаанаа тэлж, шинжлэх ухааны хэд хэдэн салбарыг хамарсан сэтгэгч байхын тулд оюуны эрсдэл бүхий алхам хийж, мандарин хэл сурах, эдийн засаг, дэлхийн хөгжим гэх мэт урьд өмнө сонсч дуулаагүй хичээлүүдийг сурахаар сонгон авсан.

Хичээлийн бус цагаар би Харвардын Олон улсын Форумд элсэв. Уг форум нь дэлхий дахины оюутан залуусыг цуглуулж, даян дэлхийн терроризм, манлайлал, ХДХВ/ДОХ, технологи, Африкийн хөгжил гэх мэт асуудлаар ажлын хэсэг байгуулдаг. Уг форумаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын эрчим хүчний хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэхийн хэрээр цаг уурын өөрчлөлтийн асуудал улам бүр газар авч байгааг мэдэж авсан. Энэхүү аюул нь үнэхээр үлэмж аюултай хэдий ч байгальд ээлтэй технологи гаргаж авах хувьсгал хийх боломж юм.

Цаг уурын өөрчлөлтийн асуудлыг авч хэлэлцэж байгаа нь надад нэг шинэ эрмэлзэл төрүүлсэн: пуужингийн шинэ түлш гаргаж авах тал дээр олж авсан туршлага болон Харвардад сурч буй одоогийн бололцоон дээрээ тулгуурлан цаг уурын хямралыг үгүй хийх шинэ үеийн автомашин болон пуужингийн түлш боловсруулах явдал юм. Одоогоор би синтетик биологи болон дахин сэргээгдэх эрчим хүчний салбар дахь тэргүүн туршлагуудыг судалж, Африкийн тогтвортой хөгжлийг хангах, тус тивийн оюуны чадавхийг гаргаж ирэхэд хувь нэмрээ оруулах бодолтой байна.

Африк гаралтай соёлоос Америкийн нийгэмд шилжин амьдрах болсноор бидний хоорон дахь ялгаатай соёл заншлын үнэ цэнийг улам мэдрэх болсон. Би оройн цагаар нийгмийн шударга ёс болон генетикийн ёс зүй зэрэг асуудлаар явагддаг байсан оюутны дотуур байрны мэтгэлцээнд орж, бусад оюутны үзэл бодол дээр тулгуурлан үзэл бодлоо олж төлөвшүүлсэн. Хэдийгээр бид харилцан адилгүй ч, бид эрх чөлөө шударга ёсны суурь үнэ цэнийн тухайд адил бодолтой ба бие биенийхээ соёл заншлыг хүлцэн тэвчиж, илүү ойлгох замаар эдгээр үнэт зүйлийг бүрдүүлж болно гэдгийг ойлгосон.

Анхны цасыг үзээд баярлах зэрэг бусад энгийн мөчүүд намайг Америк оронд дассаныг харуулж байна. Би зүүн хойд зүгийн өвлийн хүйтэнд маш их даарч, Африкийнхаа халуун нарыг мөрөөдөж байсан хэдий ч сэтгэл зүрх минь америк

I will soon return to South Africa, enriched not only by a great education but also from the interactions with people from around the globe whose opinions have given me more insight on how the world works and thinks. I may not be able to predict what the future holds, but I am excited at how my engineering education will enable me to achieve my aspirations for Africa.

хүмүүсийн халуун дотно сэтгэлд бүлээсч, дэлхийн иргэн болоход нөлөөлж байна.

Би удахгүй Өмнөд Африк руугаа буцна, агуу боловсрол эзэмшиж баяжаад зогсохгүй дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүстэй ярьж хөөрч байсны дүнд энэ дэлхий хэрхэн ажиллаж, сэтгэж явдгийг мэдэж авсан. Ирээдүйд чухам юу болохыг тааж мэдэх аргагүй ч инженерчлэлийн салбарт миний олж авсан боловсрол Африкийн төлөөх зорилгоо биелүүлэхэд тус болно гэдэгт баярлаж байна.

Why It's Important

The Case for International Education

Allan E. Goodman

Pursuing an education in a foreign country allows a young person to develop the skills necessary to become an effective and productive global citizen. Allan E. Goodman is president and chief executive officer of the Institute of International Education, the leading not-for-profit organization in the field of international educational exchange and development training.

The idea that people should strive to act as global citizens has begun to take hold around the world on an unprecedented scale. We see it everywhere:

- The antipoverty group Oxfam says that a global citizen is someone who "is aware of the wider world and … respects and values diversity."
- U.S. Secretary of State Hillary Rodham Clinton urged 2009 graduates to become "the special envoys of your ideals" as "citizen ambassadors using your personal and professional lives to forge global partnerships."
- The Chinese government invented the slogan "One World One Dream" for the 2008 Beijing Olympic Games.

Энэ яагаад чухал вэ

Олон улсын боловсролын тухай

Аллан И. Гүүдмэн

Гадаадын улс оронд боловсрол эзэмших нь залуу хүнийг бүтээмжтэй, бүтээлтэй дэлхийн иргэн болон төлөвших ур чадварт суралцах боломж олгодог. Аллан И. Гүүдмэн нь Олон улсын боловсролын хүрээлэнгийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал бөгөөд олон улсын боловсролын солилцоо, хөгжлийн сургалт олгох чиглэлээрх ашгийн төлөө бус байгууллагыг тэргүүлдэг нэгэн.

Хүмүүс дэлхийн иргэн болохын төлөө хичээх хэрэгтэй хэмээх үзэл бодол дэлхийн аль ч улс оронд урьд урьдаас илүүтэй газар авах болжээ. Бид үүнийг алхам тутамдаа харж байна:

- Ядуурлын эсрэг тэмцдэг ОксФам байгууллагынхан дэлхийн иргэн гэж ямар хүнийг хэлэх вэ гэвэл "гадаад ертөнцийг сайн мэддэг... өөр өөр соёл заншлыг хүндэлдэг, бас үнэлдэг хүнийг хэлнэ" гэжээ.
- АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Родхэм Клинтон 2009 оны төгсөгчдөд хандаж "даян дэлхийн нөхөрлөлийг бэхжүүлэхэд хувийн болон мэргэжлийн амьдралаа зориулж, иргэний нийгмийн идэвхтэй төлөөлөгчид" болохыг нь онцлоод, "хүсэл зорилгынхоо тусгай элч нь байхыг" уриалсан.
- Хятадын Засгийн газар 2008 онд болж өнгөрсөн Бээжингийн Олимпийн үеэр "Нэг ертөнц, нэг мөрөөдөл" гэсэн уриа дэвшүүлсэн.

Олон улсын Боловсролын хүрээлэн (ОУБХ) жил тутам 20,000 гаруй оролцогчдод боломж олгож, эрдэм, ажлын солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэг. Эдгээр хөтөлбөрийн дийлэнх нь

The Institute of International Education (IIE) administers more than 250 programs that help make academic and professional exchanges possible for more than 20,000 participants annually. Many of these programs help bring international students to study in the United States. One of the most well-known is the Fulbright Program, sponsored by the U.S. Department of State's Bureau of Educational and Cultural Affairs. Fulbright aims to increase mutual understanding between the peoples of the United States and other countries. Through it, people and ideas are transformed.

In an ever-changing world, being a global citizen requires constant adaptation to new ideas and circumstances. This is why the process of transformation that foreign students experience as part of a U.S. education is so important: It prepares you for the constant transformation that will be required in

Students at Egypt's Cairo University listen as U.S. President Barack Obama trumpets the value of international dialogue.

© AP Images/Ben Curtis

Египтийн Каир хотын их сургуулийн оюутнууд АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама олон улсын гэрээ хэлэлцээрийн үнэ цэнийн талаар үг хэлж байгааг сонсож байгаа нь.

олон улсын оюутнуудыг АНУ-д суралцах боломж олгодог. Эдгээр дундаас хамгийн алдартай нь Фулбрайтийн хөтөлбөр бөгөөд уг хөтөлбөрийг АНУ-ын Төрийн Департаментын Боловсрол Соёлын Харилцаа эрхэлсэн Товчоо ивээн тэтгэдэг. Фулбрайт хөтөлбөр АНУ-ын ард түмэн болон бусад улс гүрэн хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх зорилготой. Энэ хөтөлбөрөөр дамжуулан хүмүүс ба үзэл санаанууд өөрчлөгдөн шинэчлэгддэг.

Байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг дэлхийд дэлхийн иргэн байхын тулд шинэ санаа оноо, нөхцөл байдалд байнга дасан зохицож байхыг шаарддаг. Тийм болохоор гадаадын оюутнууд АНУ-д боловсрол эзэмшихийн зэрэгцээ үзэл санааны хувьд өөрчлөгдөх үйл явц нэн чухал:

a 21st-century career. Recently, a Fulbright alumnus named S.M. Krishna became India's external affairs minister. The press credited him with helping to turn Bangalore into India's most recognized technology hub, and it also cited his U.S. education as evidence that he would be able to navigate India's complex diplomatic challenges. Technology and foreign relations in India today operate on dramatically different levels than they did in the late 1950s and early 1960s, when Krishna studied on a Fulbright grant. Yet his education in the United States, where he studied at George Washington University and Southern Methodist University, played a critical role in preparing him to adapt to these contemporary challenges.

By coming to the United States, you will have a chance to reevaluate your views on your strongest beliefs and get a fresh look at the field of study that compels you the most. Doing so will put you at an economic advantage as you acquire the kind of intercultural communication skills that today's employers value, and at an intellectual advantage as you gain a deeper understanding of your values and a broader perspective on the world around you. Making "international" a part of education signals a

On his June 2009 trip to Egypt, President Obama pledges his support for exchange programs and exhorts young people to recognize the "common aspirations" between cultures.

© AP Images/Ben Curtis

Ерөнхийлөгч Барак Обама 2009 оны 6-р сард Египтэд айлчлах үедээ солилцооны хөтөлбөрийг дэмжинэ гэдгээ илэрхийлээд хүүхэд залуусыг соёл заншлууд дундахь "нийтлэг тэмүүллүүдийг" хүлээн зөвшөөрөхийг уриаллаа.

энэ нь чамайг 21-р зуунд ажиллаж амьдрахад шаардагдах байнгын өөрчлөлт шинэчлэлтэд бэлдэж буй хэрэг юм. Саяхан Фулбрайтын хөтөлбөрийн нэр хүндтэй төгсөгч С. М. Кришна Энэтхэгийн гадаад хэргийн сайд боллоо. Хэвлэл мэдээллийнхэн түүнийг Бангалорыг Энэтхэгт хамгийн их хүлээн зөвшөөрөгдсөн технологийн төв хэмээн хүлээн зөвшөөрөгдөхөд хувь нэмээ оруулсан гэдгийг өндрөөр үнэлсний зэрэгцээ түүний АНУ-д боловсрол эзэмшсэн явдал нь Энэтхэгийн дипломат харилцааны ээдрээтэй сорилтуудыг даван туулж чадна гэдгийг харуулах баримт хэмээн дүгнэжээ. Энэтхэг улс дахь технологи, гадаад харилцаа өнөөдөр Кришнаг Фулбрайтын тэтгэлгээр суралцаж явсан 1950-иад оны сүүл, 1960-аад оны эхэн үетэй харьцуульшгүй өндөр түвшинд хүрчээ. Гэвч АНУ-д олж авсан түүний боловсрол, Жорж Вашигтоны их сургууль, Өмнөдийн Методист их сургуулиудад сурч байсан нь түүнийг орчин цагийн эдгээр сорилд бэлдэхэд гол үүрэг гүйцэтгэсэн.

АНУ-д хүрэлцэн ирснээр та өөрийн гүн бат итгэдэг үзэл санаа, хатуу итгэл үнэмшлийнхээ талаар ахин эргэцүүлж, таныг хамгийн их татдаг чиглэлийн судалгааг шинээр харах боломж гарна. Ингэснээрээ та өнөөгийн ажил олгогчдын өндрөөр үнэлдэг олон улсын соёлуудын дунд харилцах чадварыг зэмшиж байгаа болохоор эдийн засгийн хувьд ашигтай төдийгүй оюуны сэтгэл ханамжийн тухайд өөрийн үнэт зүйлийн талаар илүү гүнзгий ойлголттой болж, хүрээлэн буй ертөнцийн талаар илүү өргөн хүрээний мэдлэгтэй болно. Боловсролын аль нэг хэсгийг "олон улсын" болгосноор та бидний дээд боловсролоос авч буй үйл ажиллагаанд ихээхэн дэвшил гарч байгааг харуулж байгаа хэрэг юм. Энэ нь бидний зөвхөн хэл ярианд нөлөөлөөд зогсохгүй унших, ярих

profound shift in what all of us can take away from higher education. It affects not only what we say but also what we choose to read and talk about, and how we actually think. It can make countries better friends and the world a less dangerous place.

Speaking in Cairo in June 2009, U.S. President Barack Obama noted that education and innovation will be the currency of the 21st century, and that therefore, "we will expand exchange programs and increase scholarships, like the one that brought my father to America." He considers education and exchange to play a key role in bringing the world's peoples together, saying, "I believe that America holds within her the truth that regardless of race, religion, or station in life, all of us share common aspirations — to live in peace and security; to get an education and to work with dignity; to love our families, our communities, and our God. These things we share. This is the hope of all humanity."

Cross-Border Communication

While many international students are aware of the economic and personal benefits of studying abroad, many come to the United States not so much to become global citizens as to learn the mechanics of specific fields such as business and engineering. In fact, these two fields together account for more than 36 percent of all international students in the United States, according to the IIE's Open Doors 2008 report.

Many more might aspire to earn prestigious degrees such as an MBA from Harvard or a PhD from the California Institute of Technology, but never are able to leave their home countries to pursue that dream. Issues such as high cost and the extreme selectivity of such programs can dissuade students from seeking an international education. "After all," a student from China or India might think, "the mechanics of engineering are the same everywhere, and my country's universities have improved their programs in recent years."

сэдвийн сонголт, бидний сэтгэлгээнд нөлөөлдөг. Энэ нь улс орнуудыг ойртон нөхөрлүүлж, дэлхий ертөнцийг илүү амар амгалан газар болгоход тусалж чадна.

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама 2009 оны 6-р сард Каирт хэлсэн үгэндээ 21-р зууны үнэт зүйл нь боловсрол ба шинэ санаачлага байна гэдгийг онцлон дурдаад, "ийм учраас эцгийг минь АНУ-д анх ирүүлж байсан тэр тэтгэлэгт хөтөлбөрийн нэгэн адил солилцооны хөтөлбөрийн хүрээг тэлж, тэтгэлгийг нэмэгдүүлэх болно" гэж тэмдэглэсэн. Тэрээр боловсрол ба солилцооны хөтөлбөр нь даян дэлхийн хүмүүсийг ойртуулан нягтруулахад гол үүрэг гүйцэтгэдэг гэж онцлон дурдаад, хэлсэн үгэндээ "Америкт байдаг чин үнэн бол арьс өнгө, шашин, нийгэмд эзлэх байр сууриас үл хамааран бид бүгд нэг ижил зүйлд зорьж тэмүүлж явдаг- энэ бол амар амгалан, аюулгүй орчинд амьдрах, боловсрол эзэмшиж, нэр төртэй ажиллах, гэр бүл, нийгэм, Бурхан тэнгэрээ хайрлах явдал юм. Бид бүгд эдгээр зүйлийг мөрөөддөг. Хүн төрөлхтөн нийтээрээ эдгээр зүйлд найддаг" гэж хэлсэн билээ.

Хилийн чанад дахь харилцаа

